



# **ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭ (ХАХХ) 2012-2016**

---

**Монгол Улсын Засгийн Газар,  
НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага хоорондын  
хамтын ажиллагаа, түншлэлийн баримт бичиг**

**УЛААНБААТАР ХОТ, МОНГОЛ УЛС  
2012 ОНЫ 10 ДУГААР САР**



**АГУУЛГА**

**Хуудас**

УДИРТГАЛ	4
ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭ	5
ТОВЧИЛСОН НЭРСИЙН ЖАГСААЛТ	7
1. ОРШИЛ	8
2.НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ	9
А. ҮНДЭСНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ	9
• Хүнсний баталгаат байдал ба хүнс тэжээл	9
• Хөдөө аж ахуй ба холбогдох үйлдвэрлэл	10
• Монгол Улс дахь нэмүү өртгийн сүлжээ	11
• Малын үржил ба холбогдох үйлдвэрлэл	11
• Байгалийн баялаг ба ойн нөөц	11
• Ан амьтад ба загасны нөөц	12
• Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл	12
Б. ҮНДЭСНИЙ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, БОДЛОГЫН ТОЙМ	13
В. МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ЗОРИЛТУУД (МХҮЗ) БА НҮБХТХ	16
• Ядуурлыг бууруулах	16
• Хүйсийн тэгш байдал	16
• Байгаль орчин ба тогтвортой хөгжил	17
Г. ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦОО БА ҮНДЭСНИЙ ОРОЛЦОГЧИД	17
3. ХХААБ-ЫН ДАВУУ ТАЛУУД БА ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД	18
4. ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ	22
5. ТААМАГЛАЛ БА ЭРСДЛҮҮД	26
6. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	26
7. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ	27
8. ШААРДАГДАХ НӨӨЦ БА НӨӨЦИЙГ ДАЙЧЛАХ СТРАТЕГИ	27
9. ХАВСРАЛТУУД	28
А. ХАХХ-ний тэргүүлэх чиглэлийн хүснэгт	28
Б. ХАХХ-ний үр дүнгийн хүснэгт (А хэсэг)	31
В. ХАХХ-ний үр дүнгийн хүснэгт (Б хэсэг)	48
Г. ХХААБ-аас Монгол улсад хэрэгжүүлсэн ба хэрэгжүүлж буй зарим төсөл хөтөлбөрүүд	52
Д. Голланд өвчин: Монгол улсын Хөдөө аж ахуйн хөгжлийн асуудал	54

## УДИРТГАЛ

Хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээ (ХАХХ) нь Монгол Улсын Засгийн газар (МУЗГ) болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллагын (ХХААБ) хооронд 2012-2016 онд стратегийн хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээг тогтоох хамтарсан баримт бичиг юм. Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам (ҮХААЯ) ба Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (БОНХЯ)-ны саналыг үндэслэн боловсруулсан ХАХХ-т Монгол Улсын Засгийн газраас хөдөө аж ахуй, загас, ой, байгалийн нөөцийн талаар баримтлах үндэсний хөгжлийн бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд ХХААБ-аас дэмжлэг туслалцаа үзүүлэх тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааг тодорхойлсон болно.

ХАХХ-г “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого” (2003), Улсын Их хурлаас баталсан “МХЗ-д суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого” (2008-2021), Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого” (2009), “Атрын гуравдугаар аян” газар тариаланг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (2008-2010), “Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөр (2009-2016) болон “Монгол мал” үндэсний хөтөлбөр (2010-2021) зэрэгт тодорхойлогдсон үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдэд үндэслэн боловсруулсан болно. Түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Туслалцааны Хүрээ (НҮБХТХ 2012-2016), Мянганы хөгжлийн зорилтууд (МХЗ) болон ХХААБ-ын стратегийн хүрээнд тусгагдсан зорилтууд, тус байгууллагын 2010-2013 оны дунд хугацааны төлөвлөгөө, үйл ажиллагааны хөтөлбөр, төсөв зэрэг баримт бичигтэй уялдуулан хийв.

ХАХХ хэрэгжих хугацаанд Монгол Улсын Засгийн газар, иргэний нийгэм, олон нийт ХХААБ-аас ямар төрлийн дэмжлэг авах боломжтой, эдгээрт хичнээн хэмжээний санхүүжилт шаардагдах зэргийг үнэлгээ тооцоотойгоор боловсруулснаар уг баримт бичиг ХХААБ-ын оролцоог улам ил тод, урьдчилан харах боломжтой болгосон юм. ХАХХ нь Үр дүнд суурилсан менежментийн (ҮДСМ) зарчмаар боловсруулагдсан тул ХХААБ-аас дэмжих стратегийн салбар, хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт, үр дүн, шалгуур үзүүлэлтүүдийг харуулсан хүснэгтүүд, хяналт шинжилгээ, үнэлгээний хүрээ зэргийг мөн агуулж байгаа болно.

Хөдөө аж ахуй, хүнсний баталгаат байдлыг дэмжихэд тэргүүлэн оролцдог НҮБ-ын салбар байгууллагын хувьд, ялангуяа хүнсээр дотоодын хэрэгцээг бүрэн хангадаг болох, тусламж авах хэрэгцээг бууруулах болон гамшгийн хор хөнөөлийг нөхөх стратеги хэрэгжүүлэхэд ХХААБ-ын гүйцэтгэх үүргийг энэхүү баримт бичигт тодорхой тусгасан болно. Түүнчлэн хүнсний баталгаат байдлыг тогтвортой хангахын тулд газар тариалан, мал аж ахуй эрхлэгсдийн амьжиргааг хамгаалах, сайжруулахыг онцлохын хамт тэргүүлэх чиглэл, давуу тал ба үүрэг гүйцэтгэгч талуудын оролцоог тодорхойлсон гол зарчмуудад тулгуурлан газар тариалан, мал аж ахуй, байгалийн нөөцийн менежментэнд гамшгийн эрсдлийг бууруулах (ГЭБ) явдлыг зорилго болгов.

ХАХХ нь ХХААБ-аас ирэх таван жилд хийхээр төлөвлөж байгаа ажил болон түүнийг гүйцэтгэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг хандивлагчид болон бусад оролцогч талуудад товч, тодорхой танилцуулж нөөцийг дайчлах хэрэгсэл болох юм. Гэвч ХАХХ нь бодлогын тунхаглалын баримт бичиг тул түүний зорилго, зорилтыг биелүүлэхэд бүх оролцогч талын түншлэл, хамтын хүчин чармайлт шаардлагатай гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

## ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭГ (ХАХХ) ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

Монгол Улсын Засгийн газрыг цаашид “Засгийн газар” гэх, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагыг цаашид “ХХААБ” гэх,

ХХААБ-ын стратегийн хүрээ, 2010-2013 оны дунд хугацааны төлөвлөгөө болон Монгол Улсын “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого (2003), “МХЗ-д суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого” (2008-2021), Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого” (2009), “Атрын гуравдугаар аян” газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих үндэсний хөтөлбөр (2008-2010), “Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөр (2009-2016), “Монгол мал” (2010-2021) хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх хоёр талын зөвшилцөл болон хамтын ажиллагааг бататган,

Монгол Улсын хөдөө аж ахуй, загас, ой, байгалийн нөөцийн менежмент, хөдөөгийн хөгжлийн салбарыг хөгжүүлэхэд Засгийн газар, ХХААБ-ын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэн, дурдсан салбаруудад хоёр талын болон бусад оролцогчдын харьцангуй давуу тал ба чадавхийг хүлээн зөвшөөрч, хуримтлуулсан туршлага, сургамжаа солилцсоны үндсэн дээр дараах зүйлийг тохиролцов. Үүнд:

Улс	Монгол Улс
Нэр	Хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээ (ХАХХ)
Агуулга	Засгийн газар, ХХААБ 2012-2016 онд хамтран ажиллахаар сонгосон тэргүүлэх чиглэлийн хүрээ
Тэргүүлэх чиглэл	<p><b>ХАХХ-ний тэргүүлэх чиглэл 1:</b> Малын чанар, эрүүл мэнд, ашиг шимийг сайжруулж бэлчээр, тэжээл, усны хангамжийг нэмэгдүүлэх замаар мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх</p> <p><b>ХАХХ-ний тэргүүлэх чиглэл 2:</b> Байгаль орчинд ээлтэй технологи, усалгаа, сэлгээний дэвшилтэт технологи нэвтрүүлж таримлын төрөл зүйлийг олшруулан газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих</p> <p><b>ХАХХ-ний тэргүүлэх чиглэл 3:</b> Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд дасан зохицож, даван туулах, удирдах зорилгоор байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хөгжүүлэх</p> <p><b>ХАХХ-ний тэргүүлэх чиглэл 4:</b> Нэмүү өртгийн сүлжээ бий болгох: хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын стандарт, маркетингийг сайжруулах</p>
Хамрах хүрээ	Улс орон даяар
Хариуцагч	ҮХААЯ, БОНХЯ, ХХААБ
Түншлэгч	ЗГ-ын яам, газар, агентлагууд, хандивлагчид, НҮБ-ын байгууллагууд, хувийн хэвшил, ИНБ, ТББ
Хэрэгжих хугацаа	2012-2016 он
Төсөв	432.3 сая ам. доллар

ХХААБ, Монгол Улсын Засгийн газар хамтран хөдөө аж ахуй, загас, ой, байгалийн нөөцийн тогтвортой хөгжлийн үр дүнд илүү анхаарч дараахийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- а) Голлох байгууллага, бодлого, стратегийг бэхжүүлэх талаарх хүчин чармайлт, хэрэгжүүлэх төлөвлөгөөг чадавхийг сайжруулах замаар дэмжинэ.
- б) Ил тод, Монгол Улс тэргүүлсэн үр дүнгийн хүрээ ба платформ боловсруулж харилцан тохиролцсон хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдээс тодорхой тооны зорилго, үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлон гаргаж тэдгээрт үндэслэн гүйцэтгэлийг үнэлэх; ХАХХ-г амжилттай, үр дүнтэй хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэхийн зэрэгцээ явцын хяналт шинжилгээ, боломжтой тохиолдолд нөлөөллийн үнэлгээ хийлгэж шаардлагатай бол бодлогын шийдвэрт тусгах асуудлыг тодорхойлж ажиллана.
- в) ХАХХ-г хэрэгжүүлэх салбаруудад бүх талын идэвхитэй оролцоог хангах зорилгоор явцын хамтарсан үнэлгээ хийхэд идэвхи зүтгэл гаргаж ажиллана.
- г) Бодлогын шийдвэрийг харилцан мэдээлэх болон хөрөнгө оруулалтыг удирдахад зориулж хүйсээр задлан ангилсан мэдээ бэлтгэх, түгээх, ашиглахад идэвхи зүтгэл гаргаж улмаар төрөөс зарцуулж буй хөрөнгийн үр өгөөжийг хүмүүст хүйс харгалзахгүйгээр тэнцүү хүртээх нөхцлийг бүрдүүлнэ.
- д) Хүйсийн тэгш байдлыг хангаж эмэгтэйчүүд, залуучуудыг чадавхижуулан тэднийг ХАХХ-нд боловсруулж хэрэгжүүлэх бүх хөтөлбөр, төсөлд оролцуулна.
- е) Өмнөд-Өмнөд ба гурван талт хамтын ажиллагааны ололт амжилт болон хамтын хүчин чармайлтын давуу талыг хүлээн зөвшөөрч эдгээр арга замыг бүрэн ашиглана.
- ё) Өмнөд-өмнөдийн хамтын ажиллагаанд оролцогчдын хооронд мэдлэг солилцох, хамтын ажиллагааг уялдуулах сүлжээ бий болгож бусад хөгжиж буй орны туршлагаас суралцана.
- ж) Өмнөд-Өмнөд ба гурван талт хамтын ажиллагаанд амжилттай оролцох орон нутгийн ба үндэсний чадавхийг бэхжүүлэх идэвхи зүтгэлийг дэмжиж ажиллана.
- з) ХАХХ-нд тогтвортой хөгжил, өсөлт бий болгох, ядуурлыг бууруулах зорилготой хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог хангана.
- и) ХАХХ-нд харилцан үр өгөөжтэй хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах зорилгоор төр хувийн хэвшлийн түншлэлийн инновацийн хөтөлбөр, схем хамтран боловсруулна.
- й) ХАХХ-ний хөтөлбөр, төслийн салшгүй хэсэг болсон уур амьсгалын өөрчлөлтийн талаар баримтлах үндэсний бодлого, төлөвлөлтийг дэмжинэ.
- к) Тусламжийн үр өгөөжийг нэмэгдүүлэх Парисийн тунхаглалын хариуцлагатай байх, уялдаа холбоог хангах, хариуцлага хүлээх, ил тод байх, үр дүнд суурилсан менежмент хэрэгжүүлэх үзэл санааг хамтран хэрэгжүүлнэ.


ХАХХ (2012-2016)-г Монгол Улсын Засгийн газар, ХХААБ хамтран эзэмшиж хэрэгжүүлэх үүрэг хүлээснийг баталсан болно.

Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж



Халтмаагийн Баттулга  
Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд  
04.10.2012

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн  
байгууллагыг (ХХААБ) төлөөлж



Перси В. Мисика  
ХХААБ-аас Монгол Улсад суух  
Суурин төлөөлөгч  
04.10.2012

## ТОВЧИЛСОН НЭРСИЙН ЖАГСААЛТ

АХБ	Азийн хөгжлийн банк
ДХААХББХ	Дэлхийн хөдөө аж ахуй, хүнсний баталгаат байдлын хөтөлбөр
ЕХ	Европын холбоо
ХААТ	Хөдөө аж ахуйн тооллого
ХАХХ	Хамтын ажиллагааны хүрээний баримт бичиг
ИНБ	Иргэний нийгмийн байгууллагууд
ЕК	Европын комисс
ГХХ	Гадаад харилцааны хэлтэс
ТТЗТН	Техникийн туслалцааг зохицуулах төслийн нэгж (ТТЗТН)
ОГ	Ойн газар
ХХААБ	Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
ХХААБСТ	Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын суурин төлөөлөгч
ДДБОС	Даян дэлхийн байгаль орчны сан
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ЭЦЭХ	Эгзэгтэй цэгийн эрсдлийн хяналт
ОУЦЭА	Олон улсын цөмийн энергийн агентлаг
ХААХОУС	Хөдөө аж ахуйн хөгжлийн олон улсын сан
ЯДЧХАА	Японы далайн чанад дахь хамтын ажиллагааны агентлаг
МСС	Мянганы сорилын сан
МХЗ	Мянганы хөгжлийн зорилт
ГХХЯ	Гадаад харилцаа худалдааны яам
СЯ	Сангийн яам
ҮХААЯ	Үйлдвэр хөдөө аж ахуйн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
НХХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
ПГ	Парламентийн гишүүн
МТ	Монгол төгрөг
МУХААИС	Монгол Улсын хөдөө аж ахуйн их сургууль
МУШТИС	Монгол Улсын шинжлэх ухаан технологийн их сургууль
ХААҮШУОНТ	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх төв
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ҮХС	Үндэсний хөгжлийн стратеги
ТББ	Төрийн бус байгууллага
ХББҮХ	“Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөр
ҮҮХ	Үндэсний удирдах хороо
ҮСГ	Үндэсний статистикийн газар
ТХХТ	Төр, хувийн хэвшлийн түншлэл
ШХА	Швейцарийн хөгжлийн агентлаг
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ХББТХ	Хүнсний баталгаат байдлын тусгай хөтөлбөр
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ТХАХ	Техникийн хамтын ажиллагааны хөтөлбөр
ИС	Итгэлийн сан
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБМУХБ	Нэгдсэн үндэстний байгууллагын Монгол Улсыг хариуцсан баг
НҮБХТХ	Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн тусламжийн хүрээ
НҮБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
НҮББОХ	Нэгдсэн үндэстний байгууллагын байгаль орчны хөтөлбөр
НҮБХИС	Нэгдсэн үндэстний байгууллагын хүүхдийг ивээх сан
НТИС	Нэг талт итгэлийн сан
МЭҮТ	Мал эмнэлэг, үржлийн тасаг
УГ	Усны газар
ДБ	Дэлхийн банк

## 1. ОРШИЛ

Монгол Улс 1973 онд НҮБ-ын ХХААБ-ын гишүүн болсноор тус байгууллага, Монгол Улс хоорондын хамтын ажиллагааны урт хугацааны түүх эхэлсэн байна. 2009 оны 7 дугаар сард Улаанбаатар хотноо Монгол Улсад суух Шадар суурин төлөөлөгчийн газрыг нээж Хятад дахь Суурин төлөөлөгчийн газрын шууд удирдлагын дор ажиллуулж байна. Монгол Улс нь ХХААБ-аас эрдэм шинжилгээ, байгалийн нөөцийн менежмент, технологи дамжуулалт, хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, мал аж ахуйн үйлдвэрлэлийн менежмент, онцгой байдал ба хямралын дараах менежмент, ойн мэдээлэл, статистик, хүнсний чанар, аюулгүй байдал зэрэг чиглэлээр туслалцаа авч ирсэн. ХХААБ нь 2000 оноос хойш Монгол Улсад 28 техникийн туслалцааны хөтөлбөрийн (ТТХ) хүрээнд 7,512,698 ам.доллар, 7 итгэлцлийн сангийн төслийн хүрээнд 8,773,780 ам.доллар, 15 телехүнс төслийн хүрээнд 158,488 ам.долларыг тус тус зарцуулаад байна. Бүх төсөл, техникийн туслалцааг Засгийн газрын байгууллагуудын идэвхитэй хамтын ажиллагааны дүнд хэрэгжүүлсэн. ХХААБ-аас хэрэгжүүлсэн болон хэрэгжиж байгаа төслүүдийн дэлгэрэнгүй жагсаалтыг Хавсралт Г-д үзүүлэв.

Монгол Улсын хувьд эхнийх нь болох энэхүү ХАХХ-ийг Монгол Улсын Засгийн газрын хүсэлтээр Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам (ҮХААЯ) ба Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны (БОНХЯ) удирдлагын дор боловсрууллаа. ҮХААЯ-ны дэргэд төслийн удирдах хороо байгуулж бүрэлдэхүүнд нь ҮХААЯ, БОНХЯ, Сангийн яамны (СЯ) төлөөллийг оролцуулсан. ХАХХ боловсруулах үндэсний зөвлөхүүдийн баг ажиллаж бодлогын ба нөхцөл байдлын шинжилгээ хийж ажлын хэсгийн удирдамжийн дагуу хийв. Гол чиглэлийн яамд, газрууд, НҮБ-ын холбогдох байгууллагууд, бусад хөгжлийн түншүүд, ХХААБ-ын олон салбарын мэргэжлийн багуудтай зөвлөлдсөн болно. ХАХХ-ний эхний төслийг ХАХХ боловсруулах ажлыг удирдах хороо, ХХААБ-ын Бээжин дэх суурин төлөөлөгч болон Бангкок дахь бүсийн төвийн холбогдох мэргэжилтнүүд хянаж үзсэн. 2011 оны 10 дугаар сард оролцогч талуудын зөвлөлдөх уулзалт зохион байгуулж ХАХХ-ээс гарах үр дүнг нарийвчлан тодорхойлсон бөгөөд 2012 оны 1 дүгээр сард оролцогч талуудын хоёр дахь уулзалтыг зохион байгуулж өөрчлөн сайжруулсан төслийг зөвшөөрсөн. ХАХХ-ний төслийн эцсийн хувилбарыг 2012 оны 2 дугаар сард Монгол Улсын Засгийн газар ба ХХААБ-ын Ази, Номхон Далайн бүсийн төв хүлээн зөвшөөрсөн болно.

ХАХХ-г боловсруулахдаа НҮБ-ын Хөгжлийн Төлөөх Бүлгээс (НҮБХТБ) шинээр баталсан улс оронд зориулсан хөтөлбөрийг үр дүнтэй боловсруулах удирдамж буюу дараах таван зарчимд тулгуурлав. Эдгээр зарчим нь:

- Хүний эрхийг дээдэлсэн арга барил баримтлах
- Хүйсийн тэгш байдлыг хангах
- Байгаль орчны тогтвортой байдлыг хангах
- Чадавхийг хөгжүүлэх
- Үр дүнд суурилсан менежмент нэвтрүүлэх зэрэг болно.

Зарчим тус бүр ХХААБ аливаа үндэстний хөгжлийн үйл явц ба хүрээг боловсруулж хэрэгжүүлэхэд оролцох, дэмжлэг үзүүлэх түүнчлэн дэлхийн олон нийтийн хэрэгцээнд зориулсан бараа бүтээгдэхүүнийг бий болгоход дэмжлэг үзүүлэхэд мөрдөгддөг бөгөөд эдгээр нь 2009 оны 11 дүгээр сард батлагдсан Ромын зарчим буюу улс орны хөгжил, салбар хоорондын уялдаа холбоо ба түншлэл, чадавхижуулах үйл ажиллагаа, нотолгоонд суурилсан бодлого болон дэлхийн хүнсний баталгаат байдлыг хангах ажилд олон талт байгууллагуудын гүйцэтгэх үүргийг тодорхой зааж өгсөн дэлхийн хүнсний баталгаат байдлыг тогтвортой хангах зарчимд тусгагдсан байдаг.

ХАХХ-г боловсруулахдаа олон улсын тусламж ба хөгжлийн үр өгөөжийг хангах зөвшилцлийг баримтлан, НҮБХТХ-тэй уялдуулж, МУЗГ ба НҮБ-ын Монгол Улсыг хариуцсан багийн (НҮБМУХБ) 2012-2016 оны хамтын ажиллагааны чиглэл ба гарах үр дүнг судалж ажилласан. НҮБХТХ-т 2011 оны 3 дугаар сард гарын үсэг зурсан бөгөөд 2008-2021 онд хэрэгжүүлэх Үндэсний хөгжлийн цогц бодлогын тэргүүлэх чиглэл үүнд 2015 он хүртэл хэрэгжүүлэх МХЗ-ын талаар НҮБ-ын байгууллагууд ямар хамтарсан хариу өгөхийг тусгасан. Мөн Монгол Улсын эдийн засаг, нийгэм, байгаль орчны нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөж байгаа тухай тайлбарласан.



НҮБМУХБ нь НҮБХТХ-ийн хүрээнд НҮБ-ын Улс орныг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулахад баримтлах нийтлэг зарчмыг дагаж мөрдөн дараах 4 стратегийн тэргүүлэх чиглэлд МҮЗГ, иргэний нийгэм, бусад хөгжлийн түншүүдтэй хамтарч ажиллана. Үүнд:

1. Эдийн засгийн хөгжилд оролцоо, тэгш байдлыг хангаснаар ядуурлыг бууруулахад нөлөөлөх
2. Нийгмийн суурь үйлчилгээг чанартай, тэгш хүртээх, нийгмийн хамгааллын тогтвортой тогтолцоог бий болгох
3. Байгалийн нөөцийн удирдлагын тогтвортой байдал, экологийн тогтолцоо болон хүн амын эмзэг давхаргын уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох чадварыг сайжруулах
4. Хүний эрхийг хамгаалах, тэгш бус байдлыг бууруулах зорилгоор засаглалыг сайжруулах

ХАХХ нь цаг хугацааны явцад улс орны нөхцөл байдал, хэрэгцээ шаардлага өөрчлөгдөхтэй уялдан агуулгыг нь шинэчилж байх баримт бичиг юм. ХАХХ нь Монгол Улсад хүнс, мал аж ахуй, газар тариалангийн салбарын хөгжил ба байгалийн нөөцийн менежментийг төлөвлөх, удирдах нэг хэрэгсэл болно.

## **2. НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

### **А. ҮНДЭСНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ**

Монгол Улс нь дэлхийд хамгийн их таруу суурьшсан хүн амтай орнуудын нэг бөгөөд нэг км<sup>2</sup> газар нутагт дундажаар 1.75 хүн оршин суудаг. 2010 оны эцсийн байдлаар 1,564.9 мянган км<sup>2</sup> газар нутагт 2,780.8\* мянган хүн амьдарч байна. Хөдөөгөөс хот руу чиглэсэн нүүдэл зогсохгүй байгаа учраас хүн амын олонхи (2010 оны байдлаар 63.3 хувь) нь хот суурин газарт амьдарч, хүйсийн харьцаа 100 эмэгтэй хүнд 95 эрэгтэй хүн оногдож байна. Монгол Улс засаг захиргааны хувьд 21 аймаг (хот), 329 сум (дүүрэг), 1,568 багаас (хороо) бүрддэг.

2004 оноос уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өсч экспорт нэмэгдсэнээр эдийн засаг өсч ядуурлыг бууруулах тааламжтай үе эхэлсэн. 2009 онд энэ өсөлт зогссон ч 2003-2010 оны хооронд бодит ДНБ жилийн 9 орчим хувиар өсчээ. 2010 онд ДНБ одоогийн ханшаар 8,255.1 тэрбум төгрөгт хүрсэний 18 хувийг уул уурхай, олзворлох үйлдвэр, 16 хувийг хөдөө аж ахуй, 6 хувийг аж үйлдвэр, 8 хувийг бөөний ба жижиглэнгийн худалдааны салбараас тус тус олжээ. Эдийн засгийн энэхүү өсөлт нь 2002 онд 61 хувь байсан ядуурлыг 2008<sup>1</sup> он гэхэд 35 хувь болтол огцом бууруулах нөхцлийг бүрдүүлсэн. Худалдааг чөлөөлсөнөөр хүнсний бүтээгдэхүүний хангамж тогтворжсон. Улаан буудай, мах, сүү, хүнсний ногооны хангамж зохистой хэмжээнд хүрсэн нь хөдөө аж ахуйн салбар эргэн сэргэсний илэрхийлэл юм. Нэг хүнд ногдох хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдсээр мах, сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ бүс нутгийн стандартаар өндөр хэмжээнд хүрсэн байна.

Гэвч өрхийн түвшин дэх **хүнсний болон шимт тэжээллэг бодисын баталгаат байдлыг** авч үзвэл өөр дүр зураг харагдана. Ядуурал ба хүнсний баталгаат бус байдал холбоотой байдаг тул ядуурлын түвшингийн үзүүлэлтээс өрхийн түвшин дэх хүнсний баталгаат бус байдал ямар хэмжээнд байгааг баримжаалж болно. Амьжиргааны баталгаажих доод түвшинг хүнсний ба хүнсний биш гол нэрийн барааны сагсны үнээр тогтоосон гэвэл хамгийн сүүлд улс даяар хийгдсэн судалгаагаар Улаанбаатар хотын хүн амын дөрөвний нэг, аймгийн төвийн хүн амын гуравны нэг, сумын хүн амын бараг тал хувь нь ядуу амьдарч байна. Хөдөөгийн олон өрхийн амьжиргаа бэлэн мөнгөний орлогоос хамаардаг ба тэдний дунд эмзэг байдал, хүнс хүрэлцээгүй байдал далд хэлбэрээр оршсоор байна. Хөдөөд өвлийн улиралд хөдөлмөр эрхлэлт байхгүй эсвэл хангалтгүй болдог тул хүнсний дутагдал хамгийн их ордог.

Үүний зэрэгцээ микро элементийн дутагдал өндөр байгааг судалгаагаар тогтоосон. Дундаж Монгол хүний хоол хүнсний сагсанд гурил, махан бүтээгдэхүүн давамгайлж хүнсний ногоо, жимс жимсгэнэ дутагддаг. Хоол хүнсэн дэх гол витамин, эрдэс бодисын дутагдал нь хүүхдийн өсөлт бойжилтонд засаж болохгүй хоцрогдол үүсгэдэг. Монгол хүүхдүүдийн дунд Д витаминий дутагдал 41 хувь байгаагаас зүүн, баруун, өндөр уулын бүс ба Улаанбаатар хотод хамгийн их байна (ЭМЯ, НҮБХИС, Хүнсний

<sup>1</sup> Хот хөдөөд ядуурлын түвшин ялгаатай: хотод 27% (2008), хөдөөд 47% (2008) байв.

судалгааны төв, 2004). Эрүүл мэндийн яамнаас мэдээлж буйгаар бол хүүхдүүдийн 20 хувь, жирэмсэн эмэгтэйчүүдийн 11.5 хувь нь цус багадалттай байна. Мөн тав хүртэлх насны хүүхдүүдийн 21 хувь нь төмрийн дутагдалтай байна.

Монгол Улсад хүнсний баталгаат бус байдлыг дэврээдэг хэд хэдэн өвөрмөц хүчин зүйл байдаг. Үүнд:

- Уламжлалт нүүдлийн мал аж ахуй эрхлэгчид ба хөдөөгийн малчдын хүнсний хэрэглээ ба амьжиргаа аль аль нь мал аж ахуйгаас бүрэн хамааралтай байдаг. Цаг агаарын таагүй байдал (Монгол Улсад маш элбэг тохиолддог), малын эрүүл мэнд, таримлын чанарыг сайжруулахад хөрөнгө бараг зарцуулдаггүй болон амьжиргааны эх үүсвэрийн хязгаарлагдмал байдал нь тэднийг малын тооноос хэт хамааралтай болгож улмаар хоол хүнсний хувьд баталгаагүй болгодог.
- Өвөл, зун агаарын хэм огцом өөрчлөгддөг учир хүнсний хангамж, хэрэглээ улирлаар ихээхэн ялгаатай байдаг. Хавар бүх төрлийн хоол хүнсний хангамж багасаж жилийн хамгийн тарчиг цаг болдог тул үр тариа, ногоо жимс, махны үнэ нэмэгддэг. Үүний хажуугаар хоол тэжээл, калорийн хэрэгцээ шаардлага хүйтний улиралд хамгийн их байдаг. Улирлын чанартай хүнсийг боловсруулж хадгалах орчин үеийн арга технологи ч бас өвөлд хүнс хангалтгүй болоход нөлөөлдөг.
- Хөдөөд хүмүүс ерөнхийдөө хол хол зайд нягтрал багатай амьдардаг тул тэдэнд үндсэн дэд бүтэц ба нийгмийн үйлчилгээг хүргэхэд өртөг өндөртэй болж тэдний алслагдсан байдлыг улам нэмэгдүүлдэг. Уламжлалт аж ахуйгаа эрхэлдэг малчдад бусдаас үл хамаарах тээвэр, борлуулах газар үгүй тул наймаачид ирж хямд үнээр бараа бүтээгдэхүүнийг нь авахад хүрдэг. Уламжлалт аргаар боловсруулсан хүнс (мал төхөөрөх, сүү, цагаан идээ<sup>2</sup>, махан бүтээгдэхүүн боловсруулах, хадгалах аюулгүй байдлын стандарт сул) борлуулаад хангалттай ашиг олж чаддаггүй.
- Хоол тэжээлийн талаарх зохистой мэдлэг, хандлага хангалтгүйн улмаас хүнсний төрөл зүйл цөөн, зөв хооллох хэв маяг төлөвшөөгүй. Хоол хүнсний тэжээллэг чанарыг алдагдуулалгүй боловсруулж бэлтгэх арга технологи болон олон зүйлээс бүрдсэн тэнцвэртэй хүнс хэрэглэх, түүний ач холбогдлын талаар мэдлэг сул. Хүүхэд, эмэгтэйчүүдийн хувьд хангалтгүй хооллолт ихээхэн хор уршиг тарьж байгаа бөгөөд нэмэгдэл тэжээлд хэт эрт юмуу хэт орой оруулж байгаагаас хүүхдийн шимт тэжээллэг бодисын хэрэгцээг хангаж чадахгүй (хэт шингэлсэн шөл, тогтмол биш давтамжаар хооллох г.м.) байна. Ойр ойрхон жирэмсэлж хүүхдээ хөхөөр хооллодог эхчүүд шаардлагатай шим тэжээлийн бодисоо нөхөж хуримтлуулах боломжгүй байдаг.

**Хөдөө аж ахуй ба холбогдох үйлдвэрлэл** Монгол Улсын ДНБ-ийн 16 хувь, ажиллах хүчний 32 хувь, экспортын орлогын 14 хувийг бүрдүүлж байна. Сүүлийн жилүүдэд уул уурхайн үйлдвэрлэл огцом өссөнтэй холбогдон ДНБ-д хөдөө аж ахуйн эзлэх хувь буурч байгаа (Хавсралт Д дэхь Голланд өвчин буюу баялагийн хараалын хэсгийг үзэх). Тариаланд тохиромжтой эдэлбэр газар 1,180.8 мянган га (2010), үүний 290.3 мян.га нь тариалсан талбай, 274.3 мян.га нь уринш, 186.8 мян.га нь өнжөөсөн талбай, 429.4 мян.га нь атаршуулсан талбай байна. Газар тариаланд улаан буудай, арвай, овъёос, хөх тариа, гурвалжин будаа зэрэг үр тариа, тосны ургамал болон төмс, хүнсний ногоо тариалж байна. Ургамал ургалтын хугацаа богино буюу гурван сар, газар зүйн өндөрлөг байрлал, температурын хэт хэлбэлзэл болон өвөл удаан үргэлжилж хур тунадас бага унадаг зэрэг хүчин зүйлийн улмаас газар тариалангийн үйлдвэрлэл хязгаарлагдмал байдаг.

Социализмийн үед 1959-1976 оны хооронд газар тариаланг хөгжүүлэх кампанит ажлууд зохион байгуулсны дүнд 1.2 сая хүртэлх га эргэлтийн талбай бүхий бие даасан газар тариалангийн салбар үүсч хөгжсөн. Гэвч шилжилтийн үед төрийн эзэмшлийн том сангийн аж ахуйнуудыг задлан хувьчилснаар үр дагаварт нь тариалангийн үйлдвэрлэл эрс буурсан. 2008 онд МУЗГ тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх зорилгоор “Атрын гуравдугаар аяныг” эхлүүлснээр Монгол Улс улаан буудай, төмсний хэрэгцээгээ бүрэн, хүнсний ногооны хэрэгцээнийхээ 60 гаруй хувийг дотоодын үйлдвэрлэлээрээ хангадаг болсон. Энэ кампанит ажлын үеэр газар тариаланд ашиглагддаг тракторын 80 хувь, комбайны 65 хувийг шинэчилж цаашид энэ салбарыг сэргээн босгох найдвартай үндэс суурийг тавьсан.

<sup>2</sup> Хот хөдөөд ядуурлын түвшин ялгаатай: хотод 27% (2008), хөдөөд 47% (2008) байв.

Гэвч чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хураалтын дараах боловсруулалт хийх талаар олон асуудал шийдвэрлэх шаардлагатай байна. Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд **нэмүү өртгийн сүлжээ** бүрдээгүй байгаа учир Засгийн газраас хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эдийн засгийн чадавхийг бэхжүүлж дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх замаар бүтээмжийг өсгөж бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, хүрсэн ололт амжилтаа бататгах, ахиулах бодлого баримтлах шаардлагатай.

Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар боловсруулах түвшин хангалтгүй ба чанар, аюулгүй байдлын түвшин нь олон улсын стандартын шаардлага хангахгүй байна. Хүнсний хяналтын тогтолцоо, хүнсний аюулгүй байдлын стандартыг баримтлах чадавхи сул байгааг хүнсний хэрэглээтэй холбоотой өвчлөл их гарч байгаагаас харж болно. Дотооддоо үйлдвэрлэн борлуулж байгаа бүтээгдэхүүнийг чанар муутай гэж үздэг бөгөөд чанарын хяналт, баталгаажуулалтын тогтолцоо үгүй тул бүтээгдэхүүнээ экспортонд гаргахад саад бэрхшээл их учирдаг байна. Түүхий эдийг боловсруулж бүтээгдэхүүн болгоод борлуулах хүртэлх үйлдвэрлэлийн бүх шат дамжлаганд өртөг нэмэгдүүлэх шинэ бөгөөд найдвартай тогтолцоо бий болгоход ихээхэн хөрөнгө оруулах шаардлагатай. Үүнд худалдан авах, хадгалах, боловсруулах, савлах, тээвэрлэх, түгээх, эцсийн хэрэглэгчид хүргэх хүртэл бүх шатанд чанараар өрсөлдөх явдал хамаарна.

**Малын үржил ба холбогдох үйлдвэрлэл** Монголчуудын амьжиргаанд шийдвэрлэх нөлөө үзүүлдэг байсан тул энэ салбарын өсөлтийг Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжлийн гол үзүүлэлт гэж үздэг. Монгол Улсад хонь, ямаа, үхэр, адуу, тэмээг аж ахуйн зорилгоор үржүүлж байна. Ямааны ноолуур, тэмээний ноос нь ноос, ноолууран бүтээгдэхүүний үнэ цэнэтэй түүхий эд мөн боловч таван хошуу малыг нэн тэргүүнд мах, сүүний хэрэгцээгээ хангахын тулд өсгөдөг.

2010 оны мал тооллогын дүнгээр нийт 32,729.5 мянга толгой мал тоолуулсны дотор 269.6 мянган тэмээ (0.8 хувь), 1,920.3 мянган адуу (5.9 хувь), 2,176 мянган үхэр (6.7 хувь), 14,480.4 мянган хонь (44.2 хувь), 13,883.2 мянган ямаа (42.4 хувь) байна. Мал аж ахуйн салбар жилд дундажаар 240 мянган тонн мах, 335 сая литр сүү, 19.1 мянган тонн хонины ноос, 4.6 мянган тонн ноолуур, 1.2 мянган тонн тэмээний ноос, 1.3 мянган тонн хялгас, 9.9 сая ширхэг арьс шир үйлдвэрлэдэг. 2010 оны байдлаар тус салбар нь экспортын орлогын 12.5 хувийг бүрдүүлж, нийт ажиллах хүчний 34.5 хувь нь буюу 327,100 малчин уг салбарт ажиллаж байсан байна.

Монгол Улсын мал аж ахуйн салбар сүүлийн хорин жилд бүтцийн хувьд эрс өөрчлөлтөнд орж өрсөлдөх чадвар нь огцом буурсан. 1990-ээд оны өмч хувьчлалын кампанит ажлын үеэр сангийн аж ахуй, тэжээлийн аж ахуй, хөдөө аж ахуйн нэгдэл, мал эмнэлэг, мал үржлийн албадыг татан буулгаж малыг хувьчилсан. 1990-ээд онд зах зээлийн эдийн засагт шилжиж эхлэхээс өмнө мөрдөж байсан бэлчээрийн менежментийн стратеги бүрэн орхигдож одоо хүртэл малчдад соёл ахуйн үйлчилгээг хүргэх шинэ юмуу тохиромжтой тогтолцоог хөгжүүлж амжаагүй байна.

Мал аж ахуй, хөдөөгийн салбарын менежмент, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх талаар Засгийн газар, малчдын аль аль нь дорвитой зүйл хийгээгүй. Малын бүртгэл мэдээллийн сан, малын гаралтай бүтээгдэхүүнийг борлуулах тогтолцоо болон малчид, тэдний гэр бүлд үзүүлэх эдийн засаг, нийгэм, соёлын үйлчилгээ байхгүй байна. Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний тогтолцоо хангалттай хэмжээнд хөгжөөгүй. Цэвэр ба эрлийз үүлдрийн малын тоо толгой буурч генетикийн нөөцийн ашиглалт хангалтгүй болсон. Халдварт өвчний гаралт ихсэж хүн, малын өвчлөл нэмэгдсэн. Шинэ гоц халдварт өвчин тархаж, устсан байсан өвчнүүд дахин сэргэж байгаагаас малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд хязгаарлалт үүсч байгаа. Малын тоо толгой өсч байгаа боловч бэлчээрийн зохистой, тогтвортой менежмент үгүй, тэжээл ба усны хангамж хүрэлцээгүй байгаагаас мал аж ахуйн салбарын бүтээмж хангалтгүй. Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын 96.3 хувийг (115.8 сая га) бэлчээр эзэлж байгаа боловч 70 хувь орчим нь тодорхой хэмжээгээр доройтолд орсон байна. Энэ бүх хүчин зүйл нийлээд малчин өрх, малын чанар, мал аж ахуйн үйлдвэрлэлийн эрүүл байдалд ихээхэн эрсдэл үүсгэж байна.

**Монгол орны байгалийн нөөц** хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл, хүйтэн өвөл, халуун зун, хур тунадасны хомсдолд оршдог эмзэг нөөц юм. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үеэс байгалийн нөөцийг эрчимтэй ашиглаж эхэлсэн.

Монгол орны **ойн сангийн** нийт талбай 18,565.5 мянган га. Тус орны ой эх газрын эрс тэс уур амьсгалтай нөхцөлд ургадаг учир ойн бүтээмж бага, өсөлт удаан, ган хуурайшил, түймэр, хөнөөлт шавьж, өвчин зэрэг байгалийн ба хүний хүчин зүйлсийн нөлөөнд экологийн тэнцвэрт байдлаа амархан алддаг. Хууль тогтоомжийг дээрээс доош чиглэлтэй хэрэгжүүлэх ажил үр дүнгүй, иргэдийн оролцоо дэмжлэг илүү шаардлагатай байна. 1999-2010 онд улсын хэмжээнд байгалийн ойгоор бүрхэгдсэн талбай 451.6 мянган га-гаар (ойн хорогдлын 3.6 хувь гэж тооцсон) хорогдсон байна.

Шалтгаан нь ойн түймэр, хөнөөлт шавьжийн тархалт, хууль бусаар мод огтлох зэрэг байв. Тухайлбал 1999 онд 240 гаруй мянган га ой түймэрт өртсөн бол 2010 онд 772.6 мянган га ой шатсан байна. Үүний зэрэгцээ 1999 оноос хойш 96.9 мянган га талбайгаас мод бэлтгэж 650 мянган га ой хөнөөлт шавьжинд нэрвэгджээ. Ойжуулалтыг эрчимжүүлэх, иргэдийн оролцоог идэвхижүүлэх, мод тарих, далан барих, цас борооны ус цуглуулах сан байгуулахад дотоод, гадаадын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх шаардлагатай. Мөн эдийн засгийн арга хэмжээний үр нөлөө дээрхийн адил чухал ач холбогдолтой. Тухайлбал бэлчээр ба тариалангийн газрын усжуулалтыг түргэтгэх, гэр хороололд орчин үеийн орон сууц барьж түлээ түлэхийг багасгах, хууль бусаар мод бэлтгэхийн эсрэг хатуу хууль тогтоомж хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээ авах шаардлагатай. Ойг нөхөн сэргээх, хамгаалах ажил ойн салбарын боловсон хүчний чадавхи, дээрх ажилд тогтвортой хөрөнгө оруулах эх үүсвэр хангалтгүй зэргээс болж доголдож байна. Удирдлага, зохион байгуулалт, чадавхийн эдгээр асуудлыг шийдвэрлэсний дараа ойн нөөцийн ашиглалтыг сайжруулах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

**Монгол орны ан амьтад** мөн л хүнд нөхцөлд хэцүү сорилтыг туулж байгаа. Уур амьсгал дулаарах, хур тунадасны хэмжээ багасах, ой хээрийн түймэр ихсэх, цөлжилт эрчимжих, булаг шанд, гол горхи, нуур цөөрөм ширгэх, ган, зуд, хүчтэй цасан ба шороон шуурганы тоо нэмэгдэх зэрэг байгалийн хүчин зүйлээс амьтад үзүүлэх сөрөг нөлөөлөл эрчимжиж байна. Одоогийн байдлаар ихэнхи ан амьтдын тоо толгой цөөрч соргог бөхөн, цөөвөр чоно устаж үгүй болжээ. Шивэр хандгай, хар мөрний хандгай, зэгсний гахай, голын халиу, цоохондой мий, цаа буга, хар сүүлтий, алтайн хойлог зэрэг ховор, нэн ховор амьтдын тоо толгой буурсан мэдээтэй байна. Түүнчлэн элбэг хэмээн тооцож байсан тарвага, цагаан зээр зэрэг амьтдын тоо ч ихээхэн буурсан байна. Тухайлбал 1980-аад оны үед 40 сая толгой байсан цагаан зээр сүүлийн тооллогоор 5 сая болж нөөц нь буурсан байна. Ан амьтны холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, ан амьтдыг хамгаалах, зохистой ашиглах тодорхой менежмент байхгүй байгааг нэн даруй шийдвэрлэх шаардлагатай. Мөн ан амьтдыг хамгаалах, нөхөн сэргээх орчин үеийн арга технологийг эзэмшсэн боловсон хүчин дутагдалтай, байгаль орчны хяналтын нэгдсэн тогтолцоо бүрэн төлөвшөөгүй байна.

**Монгол орны загасны нөөц** бас л эрсдэлтэй байна. Үүний гол шалтгаан нь худалдааны зорилгоор хууль бусаар агнах, уул уурхай болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс болж амьдрах орчны доройтол хомсдлоос үүдэлтэй. Монгол оронд тэмдэглэгдсэн 64 зүйлийн загасны 23 хувь нь устах аюулд өртөөд байгаа, 46 хувийнх нь тархалт, тоо толгойн талаар мэдээлэл дутмаг гэж үнэлэгдсэн. Түүнчлэн агнуурын загасыг хамгаалах, өсгөн үржүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй, агнуурын загасны нөөц, байршлын судалгаа мониторингийн ажил өнөөгийн шаардлагыг хангахгүй, агнуурын загас ашиглах тогтвортой менежмент болон олборлох арга технологи стандарт байхгүй байна. Иймд агнуурын загасыг хамгаалах, үржүүлэх замаар тогтвортой популяцийн бүтцийг бий болгох, экологийн тэнцвэрт байдлыг хангах, гол мөрөн нуурын ай савыг хамгаалах оновчтой менежмент хийх шаардлага тулгарч байна.

Бүх салбарын хувьд нийтлэг асуудал бол **уур амьсгалын өөрчлөлтийн** сөрөг нөлөөлөл юм. Монгол орон өргөн уудам нутаг дэвсгэр, байгалийн арвин баялаг, олон тооны мал, газар тариаланд ашиглах боломжтой газар ихтэй боловч хөрсний үржил шим буурах, мал аж ахуйн үйлдвэрлэлийн менежмент хоцрогдох, байгалийн гамшгийн сөрөг нөлөөлөл ихсэх зэрэг уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлын улмаас хөдөө аж ахуй, хүнс, байгалийн нөөцийн салбарт нь том сорилтууд тулгарч байна.

Монгол орны газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд тэр даруй байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөлөл нь ихсэж байна. Малын тоо толгой өсч бэлчээрийг сэлгэхгүй ашиглах болсноор ялангуяа хүн ам ихтэй газруудын орчимд бэлчээрийн даац хэтэрсэн. Хатуу хуурай уур амьсгалтай, хөнгөн бөгөөд үржил шимт үе нь нимгэн хөрстэй, тариалангийн улирал богинохон зэрэг нь бас нэг хүчин зүйл юм. Үндсэн хөрсийг услахад гол мөрний усны 15-40 хувийг ашиглаж

байгаагаас урсгал сөрөг газар энэ хувь буурч урсгал дагуу газар ихсэж байгаа. Цөлжилт ихсэж ургамлын төрөл зүйл цөөрч амьтдын амьдрах орчин алдагдаж ургамал, амьтны аймагт хохирол учруулж байна.

Газар тариалангийн үйлдвэрлэлд байгалийн нөөцийг үнэ төлбөргүй ашиглаж байгаа боловч ашигтай ажиллаж чадахгүй байна. Монгол орны тариалангийн үйлдвэрлэлийн үзүүлэлтэнд үрийн чанар муу, машин тоног төхөөрөмжинд шаардагдах хөрөнгө оруулалт хийдэггүй, усалгаагүй тариалан эрхэлдэг, ургамлын эрүүл мэндийг анхаардаггүй, үйлдвэрлэл ба хураалтын дараах боловсруулалтын явцад алдагдал ихтэй учир га-гаас авах ургацын хэмжээ бага байдаг явдал орно. Үүнээс гадна төмс, хүнсний ногоо зэрэг таримлын төрлийг олшруулах асуудлыг судалдаг байгууллага маш цөөн байна.

Энэ мэтээр нүүдлийн аж ахуйгаас олох ашиг орлого буурсан тул олон хүн хот суурин газар руу нүүх болсон. Нөгөө талаар яам агентлагууд салбарын эрх ашгаа тэргүүн зэрэгт тавьдаг, хоорондоо уялдаа холбоо байхгүй, байгалийн нөөцийн ашиглалтыг хангалттай хэмжээнд хянаагүй, байгаль орчинтой холбоотой хууль тогтоомжийг хангалттай хэмжээнд хэрэгжүүлээгүй зэргээс болж хот суурин газрын байгаль орчин ихээхэн доройтолд орсон.

Иймд уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицож даван туулах асуудал бүх оролцооны үндэс суурь болох нь зүйтэй. Гамшгийн эрсдлийн менежментийг тэргүүлэх чиглэл болгож ой, ан амьтад, загасны салбарт ч нэвтрүүлэх шаардлагатай. Цөлжилт, газрын доройтлыг зогсооход усалгаатай тариалан хөгжүүлэх, тэг элдэншүүлэгийн технологи нэвтрүүлэх, усны нөөцийг хамгаалах зэргээр орчин үеийн тариалангийн технологийг нэвтрүүлж хэрэгжүүлэх хэрэгтэй. Бэлчээрийн менежментийг сайжруулж төр засаг, малчид, тариаланчдын харилцааг зохицуулах чухал хэрэгсэл болох бэлчээрийн хуулийг батлах МУЗГ-ын хүчин чармайлтыг дэмжих шаардлагатай.

## **Б. ҮНДЭСНИЙ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, БОДЛОГЫН ТОЙМ**

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл үүн дотор хүнс, хөдөө аж ахуй, байгалийн нөөцийн салбарын тэргүүлэх чиглэлийг дараах баримт бичгүүдэд тусгаж байна. Үүнд:

- А) МХЗ-д суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого (2008-2021)
- Б) Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр
- В) Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого (2003)
- Г) Төрөөс малчдын талаар баримтлах бодлого (2009)
- Д) Атрын гуравдугаар аян үндэсний хөтөлбөр (2008-2010)
- Е) Хүнсний баталгаат байдал үндэсний хөтөлбөр (2009-2016)
- Ё) Монгол мал хөтөлбөр (2010-2021)

Монгол Улсын МХЗ-д суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогод хүнс, хөдөө аж ахуй, бүсчилсэн ба хөдөөгийн хөгжил, байгаль орчны талаар баримтлах бодлогуудыг тодорхойлж 2 үе шаттай (1-р шат: 2008-2015, 2-р шат: 2016-2021) хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Энэ баримт бичигт туссан бодлогын тэргүүлэх чиглэл нь:

1. Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар орчин үеийн хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн цогцолбор байгуулах, тэдгээрийн эрсдэл даах чадварыг бэхжүүлэх, гурил, мах, сүү, төмс хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах, тэдгээрийн хангамж, чанар, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах арга хэмжээ авах.
2. Бүсчилсэн хөгжлийн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг бууруулах.
3. Байгаль орчныг хамгаалах үүнд агаар мандал, газар, эрдэс баялаг, ус, ой, ургамал амьтны аймгийг хамгаалах, эрдэс баялгийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох, цөлжилт гангийн сөрөг нөлөөллийг бууруулах, химийн хортой бодис, цацраг идэвхит хаягдлын ялгарлыг зогсоох, хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор нийгэм, эдийн засаг, экологийн цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх.



ҮХААЯ болон БОНХЯ нь 2012-2016 онд хүнс, хөдөө аж ахуй, байгалийн нөөцийн салбарт баримтлах стратегийн чиглэлийг тогтоох бодлогын төсөл боловсруулж байгаа. Эдгээр төсөлд одоо баримталж байгаа бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийн зэрэгцээ хууль эрх зүйн ерөнхий орчныг сайжруулах арга хэмжээ, тухайлбал хүнсний баталгаат байдлыг хангах, хөдөөгийн хүн амын нийгмийн хамгааллыг баталгаажуулах зорилгоор мал аж ахуйг хөгжүүлэх, бэлчээрийн менежментийн хууль боловсруулах зэрэг арга хэмжээг тусгасан. Түүнчлэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах, өртөг нэмэх, байгалийн нөөцийн менежментийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах тааламжтай орчин бүрдүүлэх юм.

“Монгол мал” үндэсний хөтөлбөр нь мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлогын үндсэн баримт бичиг бөгөөд тус хөтөлбөрийг 2010-2021 онд 2 үе шаттай хэрэгжүүлнэ. Жил бүр улсын төсвийн гурваас доошгүй хувиар санхүүжүүлэх энэ хөтөлбөр нь мал аж ахуйг уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлж зах зээлийн нөхцөлд өрсөлдөх чадвартай, эдийн засгийн үр ашигтай салбар байх нөхцлийг бүрдүүлэх зорилготой. Улмаар хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж экспортыг нэмэгдүүлэх зорилготой. Энэ зорилгыг хэрэгжүүлэхэд баримтлах тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон. Үүнд:

1. Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбар болох мал аж ахуйг төрөөс онцгой анхаарч эрх зүй, эдийн засаг, бүтэц зохион байгуулалтын нэн таатай орчинг бүрдүүлж тогтвортой хөгжлийг хангаж сайн засаглалыг хөгжүүлэх
2. Малын үржлийн ажил, үйлчилгээг нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгож малын ашиг шимийн гарц, чанарыг сайжруулан, биологийн төгс чанартай бүтээгдэхүүн, түүхий эд үйлдвэрлэж зах зээлд өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх
3. Мал эмнэлгийн ажил, үйлчилгээг олон улсын жишигт хүргэж малын эрүүл мэндийг баталгаажуулах замаар нийгмийн эрүүл мэндийг хамгаалах
4. Уур амьсгал, байгаль экологийн өөрчлөлтөнд дасан зохицсон, эрсдэл даах мал аж ахуйг хөгжүүлэх
5. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтот зах зээлийг хөгжүүлж бэлтгэл борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох, урамшуулал олгох замаар эдийн засгийн эргэлтийг хурдасгах

МХЗ-д суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогонд тусгагдсан хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих стратегийн зорилт нь: (а) газар ашиглалтыг сайжруулж усалгаатай тариаланг хөгжүүлж биотехнологи нэвтрүүлэх замаар газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, (б) нэгдүгээр шатанд газар тариалангийн үйлдвэрлэлд хөрсний элэгдлээс сэргийлэх, үржил шимийг хамгаалах, чийгийн алдагдлыг бууруулах дэвшилтэт технологи нэвтрүүлж хоёрдугаар шатанд ургацын хэмжээг нэмэгдүүлэх юм. Засгийн газар “Атрын гуравдугаар аян”-ыг үргэлжлүүлж газар тариалангийн салбарт хүрсэн ололт амжилтыг бататган зүүн, баруун бүсэд газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, “Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөрийн шинэчилсэн найруулганд хүнсний ногоо, жимс жимсгэнийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөтөлбөр нэмж оруулах шийдвэр гаргасан.

Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуйн салбарын стратегийн гол баримт бичиг “Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөрийг Засгийн газар ХХААБ-ын туслалцаатай боловсруулсан. Хөтөлбөр 2009-2012 он, 2013-2016 онд хоёр үе шаттай хэрэгжинэ. Хөтөлбөрийн зорилго нь иргэн, төр, олон нийт, хувийн хэвшлийн зохистой оролцоог хангах замаар хүн амыг тэжээллэг, аюулгүй хүнсээр жигд, хүртээмжтэй, тогтвортой хангаж эрүүл аж төрөх болон хөдөлмөрийн бүтээмжийг нь дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Хөтөлбөрийг дөрвөн гол тэргүүлэх чиглэлээр хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Хүнсний хангамж, чанар, аюулгүй байдлыг хангах эрх зүй, эдийн засаг, зохион байгуулалтын таатай орчин бүрдүүлэх
2. Хүн амыг тэжээллэг, аюулгүй хүнсээр хүртээмжтэй тогтвортой хангах, хэрэглээн дэх үйлдвэрийн аргаар боловсруулсан хүнсний хувийн жинг нэмэгдүүлэх
3. Хүнсний бүтээгдэхүүн, ундны усны эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах хяналт мэдээллийн сүлжээг боловсронгуй болгох
4. Хүнсний тэжээллэг чанарыг сайжруулах, зохистой хооллолтыг дэмжиж хоол тэжээлийн дутлыг бууруулах, зонхилох халдварт бус өвчнөөс сэргийлэх

Монгол Улсын Засгийн газар байгаль орчны доройтлыг зогсоох зорилгоор холбогдох хууль тогтоомж баталж тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлж эрчим хүч хэмнэх технологи, бохирдлыг арилгах хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулж байгаа. Түүнчлэн хөгжлийн үйл ажиллагаанд байгаль орчны асуудлыг анхаарч байх, олон улсын ба иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран байгаль орчны талаарх олон нийтийн мэдлэг мэдээллийг сайжруулах зорилт тавин ажиллаж байна.

Монгол Улсын “МХЗ-д суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого” нь ойн нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой. Ойн санд сансрын мэдээ ашиглаж, зайнаас тандан судлах аргаар хайгуул, судалгаа хийж, тархалт, бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоон ойн зураглал, ойн тогтвортой менежментийн хөтөлбөр боловсруулах, уур амьсгалыг зөөлрүүлж, цөлжилт, хөрсний эвдрэл, түйрэн, элсний нүүдэлтэй тэмцэх зорилгоор ойг нөхөн сэргээх, говь, хээрийн бүсэд мод тариалж ногоон зурвас байгуулах, ой хамгаалах ажилд дэвшилтэт менежментийн арга нэвтрүүлж, ойн сангийн 20 хүртэлх хувийг нутгийн иргэд, нөхөрлөлд гэрээгээр эзэмшүүлэн ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх зэрэг зорилт дэвшүүлжээ.

Монгол Улсын “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” -д ой, амьтан, ургамал зэрэг байгалийн нөөц баялгийг судлах, хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэсэн арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэй цогц байдлаар шийдэх, байгалийн ургамал, ойн дагалт нөөцийн экспорт болон ойн үндсэн ашиглалтын огтлолыг бүрэн хориглож, ойн сангийн нөөцийг 2 хувиар нэмэгдүүлэх, мод орлох технологи нэвтрүүлэхийг дэмжих, энэ төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж түлшний асуудлыг цогц байдлаар шийдэх, мод, модон бүтээгдэхүүний импортыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэх, ойжуулах ажилд иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, нутгийн иргэдийг түлхүү татан оролцуулах зарчим баримтлах зэрэг заалтууд орсон байна.

Монгол Улсын Засгийн газар 1998 онд ойг хамгаалах ажлыг сайжруулах зорилгоор “Ойн үндэсний хөтөлбөр”-ийг анх удаа баталсан бөгөөд улс орны шаардлага, ойн хомсдлоос шалтгаалан хөтөлбөрт (2001, 2011) нэмэлт өөрчлөлт оруулан одоо хүртэл хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн зорилт нь хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл, ойн түймэр, хөнөөлт шавьж, өвчнөөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх ажлын үр өгөөжийг дээшлүүлэх, мод сөөгний үр бэлтгэх, тарьц суулгац бойжуулах ажлыг эрчимжүүлж, гол мөрний эх, мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавьж, өвчинд нэрвэгдсэн ойн талбайг эхний ээлжинд ойжуулж, тал хээр, говь, цөлд хамгаалалтын ойн зурвас, төгөл, ногоон хаалт байгуулах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэх, ой, модны салбарын менежмент, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, ойн салбарт шинжлэх ухаан, технологийн ололт амжилтыг нэвтрүүлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэргэжлийн боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх зэрэг юм.

Монгол Улсын “МХЗ-д суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-д амьтан, ургамлын аймгийн нөөцийн хомсдолыг хязгаарлаж, тэдгээрийн байгалийн жамаар нөхөн сэргэх, тогтвортой ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, ховор, нэн ховор амьтдын популяцийг тогтвортой байлгах, хэвийн өсөлтийг хангахтай холбогдсон зохион байгуулалтыг шинэчлэн тэдгээрийг хамгаалах эдийн засаг, эрх зүйн орчинг бүрдүүлэх, зориудын аргаар үржүүлэх, тэдгээрийн удмын санг бий болгож хамгаалахад биотехнологийн ололтыг ашиглаж, биологийн найдвартай нөөцтэй болох арга замыг боловсруулах, ан амьтдын нөөц, байршил нутгийг тогтоож хамгаалах зорилгоор олон улсын байгууллага, хандивлагч орон, хувь хүмүүсийн дэмжлэгтэй урт, богино хугацааны төслийг үр ашигтай хэрэгжүүлэх болон дотоод, гадаадын хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга хэмжээ авахаар төлөвлөжээ.

Ан амьтдыг хамгаалах, нөхөн сэргээх талаар үндэсний хэд хэдэн хөтөлбөр хэрэгжиж байна. Улсын Их Хурлаар батлагдсан “Халиун бугын үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Аргал хонийг хамгаалах үндэсний хөтөлбөр”, “Монгол орны цоохор ирвэс хамгаалах үндэсний хөтөлбөр”, “Цаа бугын аж ахуйг сэргээх, цаачдын амьдралын түвшинг сайжруулах хөтөлбөр”, “Нэн ховор, ховор амьтныг хамгаалах үндэсний хөтөлбөр” зэрэг хөтөлбөр хэрэгжиж байгаа хэдий ч төсөв хөрөнгө, орчин үеийн арга технологи, мэргэжилтэй боловсон хүчин хангалтгүйгээс зохих үр дүнд хүрэхгүй байгаа. Ийм стратеги, хөтөлбөр хэрэгжүүлсэн туршлагаас харахад ховордож байгаа, ховордож болзошгүй болон нэн ховор буюу устаж үгүй болж байгаа ан амьтдын одоогийн тоо толгой, хамгаалалтанд авсан эсэхийг шинжлэх ухааны нарийн судалгаагаар тогтоож тэдгээрийг зүйлийн болон экосистемийн түвшинд нь хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авах шаардлагатай.

Монгол Улсын Засгийн газар “Агнуурын загас хамгаалах, өсгөн үржүүлэх үндэсний хөтөлбөр” баталсан. Энэ хөтөлбөрийн зорилго нь агнуурын загасны нөөцийг хамгаалах, загасны аж ахуйн бүтэц, менежментийг сайжруулахад оршино. Загасны аж ахуйн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлсон. Үүнд:

1. Агнуурын загас үржүүлэх хууль эрх зүйн орчинг сайжруулах
2. Агнуурын загасны нөөц ба нутагшсан газруудыг тогтмол судалж хянах
3. Агнуурын загасны төрөл бүрээр агнагдах загасны биеийн хэмжээ, торны хэмжээг заасан стандарт гаргах

## **В. МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ЗОРИЛТ (МХЗ) БА НҮБХТХ**

Улсын Их Хурал МХЗ-ыг бодлогын түвшинд хүчтэй дэвшүүлж 2005 онд үндэсний хөгжлийн шалгуур үзүүлэлт, 2008-2021 онд хэрэгжүүлэх МХЗ-д суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогын хүрээ болгосон. Монгол Улсын хувьд МХЗ-9 буюу ардчилсан засаглал, хүний эрхийг хамгаалах зорилтыг бүх МХЗ-ыг биелүүлэх суурь нөхцөл болгон дэвшүүлсэн онцлогтой.

2009 оны МХЗ-ын хэрэгжилтийн гуравдахь илтгэлд есөн МХЗ-ын зургаа нь 2015 он гэхэд хэрэгжих боломжтой боловч бусад гурван МХЗ-ын хэрэгжилт хангалтгүй байгааг мэдээлсэн. Тэдгээр нь ядуурлыг бууруулах, хүйсийн тэгш байдлыг хангах, байгаль орчны тогтвортой байдлыг хамгаалах зорилт юм. Ялангуяа МХЗ-1 ядуурал, өлсгөлөнг бууруулах (Зорилт 1в: 1990-2015 онд өлсгөлөнг нэг дахин бууруулах) зорилт биелэгдэх боломжгүй байгаа бөгөөд Засгийн газар 2015 он хүртэл энэ зорилтыг хэрэгжүүлэхэд онцгой хүчин чармайлт тавьж ажиллах шаардлагатай. Энэ гурван зорилт гурвуулаа ХХААБ-аас ХАХХ-ээр дамжуулан шийдвэрлэхийг зорьж буй асуудлуудтай холбоотой юм.

**Ядуурлыг бууруулах** үндэсний зорилт нь 2015 он гэхэд ядуурлын түвшинг 18.0 хувь, ядуурлын гүнзгийрэлтийг 6.0 хувь хүртэл бууруулах юм. 2010 оны өрхийн нийгэм-эдийн засгийн судалгааны дүнгээр хүн амын 39.2 хувь нь ядуу амьдарч байгаа нь 2009 оныхтой харьцуулахад 0.5 хувь, 2008 оныхтой харьцуулахад 4.0 хувиар өссөн дүн юм.

Эрх зүйн шинэчлэлтийн хүрээнд ядуурлыг бууруулах талаар дараах арга хэмжээ авсан. Үүнд:

1. Монгол Улсын “Нийгмийн халамжийн тухай” багц хууль, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хуулийн төслийг боловсруулж Их Хуралд өргөн барьсан. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хуулийн шинэчилсэн төсөлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг оновчтой болгох, зорилтот бүлгүүдэд чиглэсэн нийгмийн нэмэлт үйлчилгээг бий болгох, хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг оруулсан.
2. “Нийгмийн халамжийн тухай” хуулийн төсөлд хүн амын ядуу ба эмзэг хэсэгт чиглэгдсэн, тэдэнд үр шим хүртээх, өрхийн гишүүдийг ажлын байраар хангах, тэдэнд хүнс, эрүүл мэнд, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг салбар хоорондын асуудлыг тусгасан.

Эдийн засгийн өсөлтөнд салбаруудын оруулах хувь нэмэр харилцан адилгүй ялангуяа ядуурлыг бууруулахад тэдгээрийн гүйцэтгэх үүрэг тодорхойгүй, энэ талаар хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны уялдаа зохицуулалт хангалтгүй байна. Иймд ядуурлыг бууруулахад салбарын өсөлтийн үр нөлөөг тогтвортой байлгаж салбар хоорондын бодлого, үйл ажиллагааг зохицуулах механизм бий болгох нь зүйтэй.

**Хүйсийн тэгш байдал** Монгол орны нийгэм, эдийн засгийн ихэнхи салбарт эмэгтэйчүүд идэвхитэй оролцдог боловч эдийн засгийн боломж ба улс төрийн шийдвэр гаргах түвшинд хүйсийн тэгш бус байдал оршсоор байна. Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс бага орлого олж байгаа нь босоо ба хэвтээ чиглэлд тусгаарлалт байгааг илэрхийлнэ. 2008 оны сонгуулиар парламентэд сонгогдсон эмэгтэйчүүд нийт гишүүдийн 3.9 хувийг бүрдүүлж байсан нь МХЗ-3 буюу 2015 онд парламентийн гишүүдийн 30 хувийг эмэгтэйчүүдээр бүрдүүлэх зорилттой харьцуулахад туйлын хангалтгүй үзүүлэлт. Эмэгтэйчүүд улс төрд оролцоход сонгуулийн кампанит ажлын зардал өндөр, хүйсээр нь нэг хэвэнд оруулах, улс төр, хэвлэл мэдээллийн нөхөрсөг бус орчин зэрэг саадтай учирдаг. Хөдөөд хүйсийн асуудал ямар байгаа



тухай мэдээлэл хангалтгүй боловч үндэсний хэмжээний тоо баримтаас харахад эмэгтэйчүүдийн ажилгүйдэл эрэгтэйчүүдийнхээс өндөр байна. Тухайлбал нийт бүртгэлтэй ажилгүйдлийн 52.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Энэ үзүүлэлт хөдөөд 53.6-55.1 хувь, Улаанбаатарт 49.4 хувь байна. Хөдөөд өрх толгойлсон эмэгтэйчүүд ба 16 хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эхчүүдийн тоо өсөж 2010 онд энэ хоёр үзүүлэлт хөдөө орон нутагт 68.5 ба 63.6 хувьд хүрсэн бөгөөд нийт хүн амын 51.4<sup>3</sup> хувь нь эмэгтэйчүүд байна.

**Байгаль орчин ба Тогтвортой хөгжил** Монгол оронд газар, ус, экосистем үлэмж доройтож цөлжилт, биологийн олон янз байдал алдагдаж байгаа. Монгол бол зуд (хатуу өвөл болж гамшигийн хэмжээнд хүрэх), ой хээрийн түймэр, үер, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт өртөмтгий орон. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас гамшгийн давтамж нэмэгдэж түүнд хариу үзүүлэх механизм хангалттай хөгжөөгүй байна. Монгол Улсын нэг хүнд ногдох нүүрсхүчлийн хийн ялгарал дэлхийн дундажаас өндөр байгаагийн гол шалтгаан нь эрчим хүчний алдагдал ихтэй, олон малтайн дээр түүхий нүүрс түлшинд ашигладаг зэрэг юм. Хүн амын дөнгөж 45 хувь нь аюулгүй ундны ус хэрэглэж 28 хувь нь эрүүл ахуйн зохистой түвшинд амьдардаг. Стандарт, норм норматив баримтлах, хууль дүрмийг дагаж мөрдөх асуудал үндэсний ба орон нутгийн түвшинд хангалтгүй учраас байгаль орчны засаглал зохих түвшинд хүрээгүй байна. Уул уурхайн салбар өргөжиж байгаагаас бэлчээр доройтох, ус хөрс бохирдох, зэрлэг амьтдын нутаг алдагдах зэрэг байгаль орчны асуудал үүсч байна.

## **Г. ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦОО БА ҮНДЭСНИЙ ОРОЛЦОГЧИД**

Монгол Улсад хөдөө аж ахуйн, хөдөөгийн хөгжил, байгалийн нөөцийн менежментийн асуудлыг хариуцдаг хэд хэдэн яам, агентлаг байна. ХХААБ-ын хариуцсан асуудлаар тус байгууллагын суурин төлөөлөгчийн газартай хамтран холбогдох чиглэлийн яамдыг холбож ажилладаг гол байгууллага нь ҮХААЯ юм.

ХАХХ-г боловсруулах явцад 2011 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Улаанбаатар хотод эхний зөвлөлдөх уулзалт зохион байгуулж хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, байгаль орчны салбарын төр, эрдэм шинжилгээ, төрийн бус болон иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл оролцсон.

Уулзалтаар хүнс, хөдөө аж ахуй, ой, загас, байгалийн нөөцийн салбарын одоогийн нөхцөл байдалд хийсэн шинжилгээ болон ХАХХ-ний тэргүүлэх чиглэлийг хэлэлцсэн. Оролцогсдын санал шүүмжийг үндэслэн ХАХХ-ний эхний төслийг сайжруулж хоёр дахь зөвлөлдөх уулзалтаар танилцуулсан. Хоёр дахь зөвлөлдөх уулзалтыг 2012 оны 1 дүгээр сарын 12-нд зохион байгуулж дипломат, олон улсын хандивлагч ба Засгийн газрын байгууллагууд, чиглэлийн яамд, ТББ, ИНБ болон эрдэм шинжилгээний байгууллагуудын төлөөлөгчид оролцсон.

Уулзалтын үеэр ХАХХ-ний хоёр дахь төслийг хэлэлцүүлж, оролцогч талуудын санал, шүүмжийг үндэслэн ХАХХ-ний төслийн сүүлийн хувилбарыг боловсруулсан. **Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам (ҮХААЯ)** нь “хүнс, хөдөө аж ахуй, худалдаа үйлчилгээ болон тогтвортой хөгжлийн таатай орчин бүрдүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангахын тулд хөдөөгийн ба бүс нутгийн хөгжлийг дэмжих” зорилготой төрийн захиргааны төв байгууллага юм. ҮХААЯ нь дөрвөн тэргүүлэх чиглэл, 13 зорилт, 77 үйл ажиллагаа бүхий “Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөрийг (2009) хэрэгжүүлэх үүрэгтэй. Мөн ой, загасны дэд салбарыг хөгжүүлэх, тэдгээрийн нөөцийг зохистой ашиглах, худалдааны зорилгоор ашиглуулах зөвшөөрөл өгөх үүрэгтэй.

Дээрх зорилтыг биелүүлэхэд ҮХААЯ-ны дараах газрууд оролцоно. Үүнд: 1) Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар, 2) Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 3) Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 4) Хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар. Тус яам Мал эмнэлэг, үржлийн газар, Жижиг дунд үйлдвэрийн (ЖДҮ) газар, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх төв (ХААҮШОНТТ), Тариалан эрхлэлтийг дэмжих сан, ЖДҮ-ийг дэмжих сан, Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа зэрэг гадаад бүтцийн нэгжтэй.

<sup>3</sup> Үндэсний статистикийн газар: Статистикийн эмхэтгэл – 2010, Улаанбаатар, 2011. Хэсэг 3- 4.

**Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (БОНХЯ)** ой, ан амьтад, загас зэрэг биологийн төрөл зүйлийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх болон экологийн тэнцвэрийг хадгалах асуудлыг зохицуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй. БОНХЯ-ны харьяа Ойн газар нь ойн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, Засгийн газрын ойн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй. БОНХЯ ангуурын загасыг өрхийн хэрэгцээнд болон худалдааны зорилгоор агнах ажилд хязгаарлалт тавих бодлого баримталж байгаа.

Хүнс, хөдөө аж ахуй, байгалийн нөөцийн салбар нь байгаль, уур амьсгалын хүчин зүйлийн нөлөөллөөс ихээхэн хамааралтай байдаг тул дээрх яамд **Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ)**-тай холбоотой ажилладаг. ОБЕГ гамшгийн менежментийн салбарт ажиллаж гамшгаас хамгаалах, улсын нөөцийг бүрдүүлэх, салбар хоорондын зохицуулалт хийх төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллага. ОБЕГ нь а) гамшгаас хамгаалах эрх зүйн орчин бүрдүүлэх, б) бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх, в) гамшгийн мэдээллийн сан бүхий мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулах, г) гамшгийн менежментэнд шинжлэх ухаан, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, д) төрийн ба орон нутгийн нөөцийг зохистой болгох (хэмжээ, байршил), агуулахын аж ахуйг хөгжүүлэх үүрэгтэй. ОБЕГ-ын орон нутгийн салбарууд нь байгалийн гамшиг зэрэг онцгой байдлын үед хамгаалах, аврах, сэргээн босгох ажлыг гүйцэтгэдэг.

**Эрүүл мэндийн яам (ЭМЯ)** Монгол Улсын иргэд ялангуяа эмзэг бүлгийн (ядуу) хүмүүст чанартай эрүүл мэндийн үйлчилгээг жигд, хямд хүргэх үүрэгтэй. ЭМЯ-ны эцсийн зорилго нь эрүүл, баталгаатай, шим тэжээлтэй хүнсээр дамжуулан хүн амыг өвчин эмгэгээс сэргийлэх явдал юм.

**Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам (НХХЯ)** нь хүн амын нийгмийн хамгаалал, даатгал, тусламж, нөхөн сэргээлт болон өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгайлан туслах асуудлыг хариуцдаг.

**Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ)** Монгол Улсын нутаг дэвсгэрт хуулийг сахиулан, хүний болон нийгмийн тогтвортой хөгжил, бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой. МХЕГ нь МХЕГ-ын удирдлагад Засгийн газрын холбогдох яамдтай үйл ажиллагаагаа уялдуулах, зөв зүйтэй шийдвэр гаргах, МХЕГ-ийн бүтэц зохион байгуулалт, мэдээлэл харилцаа, санхүү, эдийн засгийн асуудлаар бодлогын зөвлөгөө өгөх үүрэгтэй. Тус газар бодлогын зохицуулалт, төлөвлөлт, хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээлэл, санхүүгийн хэлтэстэй. МХЕГ-ын харьяа 1,733 улсын байцаагч, 34 салбар ажиллаж 140 гаруй хууль, 3,600 гаруй стандарт, дүрэм, журам, парламент, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилладаг.

### 3. ХХААБ-ЫН ДАВУУ ТАЛ БА ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

Аливаа байгууллагын онцлог чанар, хүч чадал нь түүнд бодитоор байдаг өвөрмөц зүйлсээр тодорхойлогдож байдаг. ХХААБ-ын хувьд хэд хэдэн онцлог шинж байдаг ба тэдгээр нь эргээд харьцангуй давуу талыг бий болгодог. Үүнд:

1. ХХААБ нь НҮБ-ын хүнс, хөдөө аж ахуйн төрөлжсөн байгууллага бөгөөд хүнс, хөдөө аж ахуй (загас, ой, байгалийн нөөцийн менежмент), хүнсний баталгаат байдал, хүнсний шимт тэжээлийн бүх асуудлаар дэлхий дахинд үйл ажиллагаа явуулдаг.
2. ХХААБ нь засгийн газар хоорондын статустай ажилладаг, төвийг сахисан байгууллага бөгөөд дэлхийн улс үндэстнүүд нэг нь нөгөөтэйгөө зөвшилцөх, мэдлэг солилцох санал гаргавал төвийг сахисан нөхцөл бүрдүүлэх бүрэн эрхтэй.
3. ХХААБ аль ч гишүүн орноосоо тус байгууллагын зорилгод нийцсэн аливаа мэдээлэл хүсэх эрхтэй.
4. ХХААБ дунд хугацааны тэргүүлэх чиглэлд тодорхойлогдсон болон удирдах байгууллагад сонгогдсон гишүүн орнууд нь зөвшөөрч баталсан үйл ажиллагааг санхүүжүүлэх баталгаатай эх үүсвэрийг гишүүн орнуудынхаа жил бүрийн татвар, хандиваас бүрдүүлэхийн зэрэгцээ мэдлэг туршлага нэмэгдүүлж байгууллагын хамрах хүрээг өсгөх ажлынхаа үр дүнд сайн дурын хандив цуглуулж ажилладаг.
5. ХХААБ хариуцсан асуудлынхаа хүрээний олон салбарын мэргэжилтнүүдтэй бөгөөд тэдгээр нь

хоорондоо уялдаатай ажилладаг.

6. ХХААБ-ын Монгол Улсад суух төлөөлөгчийн газрыг бүс нутаг ба дэлхийн зөвлөхүүдийн баг дэмжиж ажилладаг бөгөөд улс орны хэрэгцээ шаардлаганд тохирсон хариу өгөх зорилготой.

ХХААБ нь хөгжлийн орчин болон байгууллагынхаа өвөрмөгц шинжтэй уялдуулан үйл ажиллагааны шинэ багц боловсруулж салбартаа онцгой үүрэг гүйцэтгэдэг тусгай статусын байгууллага болж хөгжиж байна. Эдгээр нь “өөр ямар ч байгууллага гүйцэтгэх боломжгүй” үйл ажиллагаа бөгөөд ХХААБ-ын салбартаа эзлэх байр суурийг баталгаажуулж байдаг.

ХХААБ-ын салбар, үйл ажиллагааг бие даасан хөндлөнгийн үнэлгээгээр (БДХҮ) тогтоосон бөгөөд “хэрэв маргааш гэхэд ХХААБ үгүй болбол” бүгдэд нь өөрчлөлт орох тийм салбар, үйл ажиллагаа юм. ХХААБ зарим салбарт дан ганцаар ажилладаггүй боловч тэргүүлэх үүрэг хүлээдэг. Ийм тохиолдолд ХХААБ бусад байгууллагатай стратегийн түншлэл байгуулан ажилладаг. Дээр дурдсан онцлог шинжийн улмаас дараах гол үйл ажиллагааг гүйцэтгэдэг. Үүнд:

1. Аливаа улс дэлхийн засаглалын механизмыг ашиглах, бодлогын яриа хэлэлцээр хийх замаар олон улсын гэрээ хэлэлцээр, ажиллах журам, техникийн стандарт, бусад заавар боловсруулж хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх.
2. Даян дэлхийг хамарсан олон улсын хөгжлийн үйл ажиллагааны талаар мэдээлэлтэй байх, түүнд оролцох, тэдгээрийг улс орон болон байгууллагынхаа түвшинд хэрэгжүүлэхэд шаардагдах бодлого, чадавхиа хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх.
3. ХХААБ-ын ажилладаг салбар, дэлхийн ба бүс нутгийн хандлага, боломж болон засгийн газар, бусад оролцогчоос авч буй хариу арга хэмжээний (бодлого, хууль тогтоомж, үйл ажиллагаа) тухай мэдээ, мэдээллийг нэгтгэх, анализ хяналт хийж хүртээмжийг нэмэгдүүлэх.
4. Дэлхий, бүс нутаг, улс орны хэмжээнд хөгжлийн үр нөлөөг сайжруулах зорилгоор засаглалыг сайжруулах, бодлогыг хөгжүүлэх.
5. Улс орны ба бүс нутгийн хэмжээнд нотолгоонд суурилсан бодлого, хөрөнгө оруулалт, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ үнэлгээ хийх чадавхийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
6. Хүнс, шим тэжээлийн баталгаат байдал, хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийг дэмжих чиглэлээр засгийн газар, хөгжлийн түнш, иргэний нийгэм ба хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх.
7. ХХААБ-ын ажилладаг салбарын асуудлаар улс, бүс нутаг, дэлхийн хэмжээнд зөвлөлдөх, харилцах асуудлыг дэмжих.

Энэ бүх үйл ажиллагаа БДХҮ-ийн “Байгууллагын зорилго нь ажиллах салбарынхаа хүрээнд хөгжлийн янз бүрийн шатанд байгаа улс орон ялангуяа ядуу буурай орнуудад шаардлагатай байгаа мэдлэг, нийтийн зориулалттай бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлэх” зарчимтай нийцэж байгаа. Энэ утгаараа ХХААБ нь дэлхийн бодлогыг тодорхойлогч, зохион байгуулагч, түншлэгч мөн “гүйцэтгэгч” байх шаардлагатай.

ХХААБ нь Монгол Улсад хуримтлуулсан туршлага, давуу талаа хуваалцаж “Хүнсний баталгаатай Ази, Номхон далайн бүс” нутгийг хөгжүүлэх бүсийн тэргүүлэх чиглэлийнхээ хүрээнд “гишүүн орнуудын байгалийн нөөцийн бааз суурийг хамгаалахын зэрэгцээ хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлж ядуурлыг бууруулах замаар шимт тэжээллэг бодисын дутагдалтай хүмүүсийн тоог 2015 он гэхэд нэг дахин буулгах” эрхэм зорилгоо биелүүлэх зорилготой ажиллана.

ХХААБ бүс нутгийн хэмжээний эрхэм зорилгоо биелүүлэхэд дараах таван стратегийн тэргүүлэх чиглэлийг зорилтоо болгон хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Хүнсний болон шимт тэжээллэг бодисын баталгаат байдлыг хангах.
2. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хөдөөгийн хөгжлийг дэмжих.
3. Байгалийн нөөцийн менежмент, ашиглалтыг жигд, бүтээмжтэй, тогтвортой байдлыг сайжруулах.
4. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын гамшиг, онцгой байдалд хариу үзүүлэх чадавхийг сайжруулах.
5. Уур амьсгалын өөрчлөлтийн хөдөө аж ахуй, хүнсний болон шимт тэжээллэг бодисын баталгаат байдалд нөлөөлөх нөлөөлөлд дасан зохицох.

ХХААБ-ын Ази номхон далайн бүсийн төв нь дээрх тэргүүлэх чиглэлийн хүрээнд үр дүн ба стратегийн зорилтыг биелүүлэх зорилгоор үр дүнд суурилсан арга барилаар ажиллана. Үүнд:

1. Чиг хандлага, боломжийг хянаж шинжлэх, үнэлэх
2. Хувь хүн, байгууллага, бодлогын түвшинд чадавхийг бэхжүүлэх, техникийн дэмжлэг үзүүлэх<sup>4</sup>
3. Дэд бүсэд бодлогын туслалцаа, зөвлөгөө өгөх
4. Түншлэл, холбоо бий болгох
5. Мэдээлэл, мэдлэг, статистик тоо баримтыг бататгах
6. Олон улсын баримт бичиг боловсруулах. АНДБТ-ийн шинэ бүтэц зохион байгуулалтаар хэрэгжүүлж гурван гол салбарыг нэгтгэсэн олон талт багуудыг бэхжүүлэх. Үүнд: (1) хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тогтолцоо, (2) эдийн засаг, нийгэм, бодлогын туслалцаа, (3) хүрээлэн буй орчин ба байгалийн нөөц

Монгол Улс дахь ХХААБ-ын шадар суурин төлөөлөгчийн газар нь “хүн амын хүнс, тэжээлийн баталгаат байдлыг хангахад манлайлагч, итгэл хүлээсэн, хариуцлагатай түнш” байна. ХХААБ тус улсад дараахь чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирсэн. Үүнд:

1. Хүнс, тэжээлийн баталгаат байдал
2. Хөдөө аж ахуйн тоо баримт
3. Усны менежмент, усалгаа
4. Хүнсний үнийн хөөрөгдлийн эсрэг арга хэмжээ
5. Малын эрүүл мэнд
6. Малын гаралтай бүтээгдэхүүний боловсруулалт
7. Байгалийн нөөцийн менежмент
8. Ой хамгаалалт
9. Хүнсний аюулгүй байдал

ХХААБ Монгол Улсад ажиллаж их туршлага хуримтлуулсан бөгөөд зарим жишээ дурдвал:

Япон Улсын Засгийн газрын 1.92 сая ам.долларын санхүүжилтээр сүү цагаан идээг боловсруулах явцад гарах алдагдлыг бууруулах, малжуулах замаар сүү, цагаан идээний хангамжийг сайжруулах зорилгоор хэрэгжүүлсэн Хүнсний баталгаат байдлын тусгай хөтөлбөр (ХБТХ) (2004-2007) ба үндэсний хэмжээнд малын генетикийн чанарыг сайжруулах ТХАХ (2007-2010) байна. Байгаль орчны салбарт 281.0 мян. ам.долларын төсөвтэй Ой хээрийн түймэр ба гамшгаас урьдчилан сэргийлэх чадавхийг сайжруулах төсөл (2003 онд хэрэгжиж дууссан) болон 319.9 мян. ам.долларын төсөвтэй Монголын ойд Сибирийн хүр хорхойн авгалдай болон бусад голлох хортонг устгах онцгой байдлын арга хэмжээ төсөл (2005) амжилттай хэрэгжсэн.

ХХААБ Хүнсний баталгаат байдлын үндэсний хөтөлбөрийг (2009-2016) боловсруулахад тусалж хэрэгжүүлэхэд нь Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагааны дагуу техникийн туслалцаа үзүүлсэн. Түүнчлэн Хүнсний үнийн хөөрөгдөлд (2009) өртсөн ногоочид, зудад (2010) нэрвэгдсэн болон мал нь шүлхий өвчнөөр өвчилсөн малчдад яаралтай тусламж үзүүлсэн. Өнөөдрийн байдлаар ХХААБ хүнсний баталгаат байдал, ойн менежмент, чадавхижуулах чиглэлээр хэд хэдэн төсөл хэрэгжүүлж байгаагийн зэрэгцээ Дэлхийн хөдөө аж ахуй, хүнсний баталгаат байдлын хөтөлбөрийн хүрээнд мал аж ахуйд суурилсан амьжиргааг дэмжих хосолсон хөтөлбөрийг удирдан хэрэгжүүлж байна (ХХААБ-аас хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж байгаа төслийн жагсаалтыг Хавсралт Г-ээс үзэх).

ХХААБ төрийн байгууллага, ИНБ, фермерүүдийн чадавхийг сайжруулах чиглэлээр арвин туршлагатай бөгөөд чадавхижуулах үйл ажиллагааг техникийн ба үйл ажиллагааны гэсэн хоорондоо ялгаатай хоёр чиглэлээр явуулдаг. Чадавхийг олон улсын тодорхойлолтын нэгэн адил “хувь хүн, байгууллага, нийгэм бүхэлдээ ажил хэргээ амжилттай хөтлөн явуулах чадвар” гэж ойлгодог. Энэ утгаараа чадавхийг бэхжүүлэх (ЧБ) гэдгээр “хүмүүс, байгууллага, нийгэм бүхэлдээ цаг хугацааны явцад чадавхиа ихэсгэх, багасгах, үүсгэх, дасан зохицуулах, хадгалах” гэж ойлгодог.

<sup>4</sup> ХХААБ-ын чадавхийг хөгжүүлэх стратегийг үзэх (<http://www.fao.org/capacitydevelopment/en/>)

Аливаа оронд энэ хоёр төрлийн чадавхи хоёулаа оршин байх нь ХХААБ-ын хөтөлбөр амжилттай хэрэгжих нөхцөл болохын зэрэгцээ тухайн орны хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн чадавхийг сайжруулахад зайлшгүй чухал. Техникийн чадавхид тухайн гишүүн орон Мянганы хөгжлийн зорилтууддаа хүрэхэд шаардагдах хүнсний баталгаат байдал, хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн өргөн хүрээний чадавхи орно. Үйл ажиллагааны чадавхид тухайн орон хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн салбартаа өөрчлөлт хийх, хийсэн өөрчлөлтөө тогтвортой байлгах чадавхи орно. Үүний үр дүнд тухайн орон өөрчлөлтийн санаачлагыг төлөвлөх, манлайлах, удирдах, тогтвортой байлгах улмаар мэргэжлийн нөгү-хауг дотоодын системдээ нэвтрүүлэн тогтвортой хөгжих боломжтой болдог.

ХХААБ үйл ажиллагааны чадавхийн дөрвөн чухал талбарыг тодорхойлсон байдаг. Үүнд:

1. Бодлого ба норматив: бодлого боловсруулж хэрэгжүүлэх, бодлогын шинэчлэл хийх чадавхи
2. Мэдлэг: мэдлэг, мэдээлэл олж авах, бий болгох, удирдах, солилцох чадавхи
3. Түншлэл: сүлжээ, холбоо, түншлэлд нэгдэх чадавхи
4. Хэрэгжүүлэлт: хөтөлбөр төслийг төлөвлөхөөс эхлээд хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ үнэлгээ хийх чадавхи

Аливаа орон хөгжлийн зорилгодоо хүрэх суурь нөхцөл нь түүний техникийн ба үйл ажиллагааны чадавхид оршихоос гадна хувь хүмүүс, байгууллагын болон тохиромжтой орчин дахь чадавхийн түвшинээс хамаардаг. Хувь хүний түвшинд хөгжүүлсэн чадавхи ур чадвар, хандлагын ялгаа үүсгэдэг. Сургалт, мэдлэг солилцох, сүлжээ үүсгэх нь энэ хэмжээсэнд чадавхижуулж байгаа хэрэг юм. Байгууллагын түвшинд чадавхижуулахад байгууллагын ерөнхий үйл ажиллагаа, гүйцэтгэлийг сайжруулах арга хэмжээ авдаг. Энэ хэмжээсэнд чадавхижуулахад байгууллагын доторх хувь хүмүүсийн мэдлэг чадвараа нэмэгдүүлж чадвараа ашиглах байдал шууд нөлөөлдөг. Байгууллага, хувь хүмүүс хоёулаа чадавхиа үйл ажиллагаандаа ашиглаж эхлэхэд тохиромжтой орчин бүрдэж чадавхийн хөгжил бодитой явагддаг. Үүнд улс төрийн үзэл бодол, алсын хараа, бодлого, хууль эрх зүй, эдийн засгийн орчин, төсвийн хуваарилалт, боловсруулалт, засаглал ба эрх мэдлийн бүтэц, урамшуулал ба нийгмийн хэв хэмжээ зэрэг орно. Монгол Улсад ЧБ-дээ ХХААБ бусад орны нэгэн адил дараах хүчин зүйлсэд анхаарч ажиллана. Үүнд:

Эхэн үе: ЧБ хэрэгцээг тодорхойлох	Боловсруулалт, хэрэгжүүлэлт	Төгсгөл үе, тогтвортой байдлын асуудлууд
<ul style="list-style-type: none"> <li>• Олон улсын санаачлагаар бий болсон хүрээг ашиглах (конвенци, гэрээ)</li> <li>• Оролцооны аргаар үндэсний оролцогчдыг даруй татан оролцуулах</li> <li>• Бодлогын хэрэгжилт, гүйцэтгэлийг сайжруулахад үндэсний оролцогчдыг оролцуулах</li> <li>• Өөрчлөлтийг хурдасгах орон нутгийн, үндэсний манлайлагчдыг тодруулах</li> <li>• Зорилтот хэрэгцээг тодорхойлох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Үндэсний, бүсийн, дэд бүсийн орчинг анхаарах</li> <li>• Чадавхийн гурван хэмжээсэнд анхаарах</li> <li>• Техникийн ба үйл ажиллагааны чадавхийг анхаарах</li> <li>• Оролцооны загваруудыг хослуулах</li> <li>• Сургалтын шилдэг арга технологийг заах арга зүйтэй хослуулах</li> <li>• Дунд ба урт хугацаанд үр дүнгээ өгөх арга замуудыг хэрэглэх</li> <li>• Мэдлэг, мэдээлэл солилцох сүлжээ бий болгох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Үндэсний оролцогчид өөрчлөлтийг тэргүүлэх чиглэл, тогтолцоо, үйл явцдаа шингээх</li> <li>• Төсвийн хуваарилалт хийх</li> <li>• Өмнөх шатны үр дүн дээр нэмэгдэж явах</li> <li>• Орон нутгийн иргэдэд эрх мэдэл олгох</li> <li>• Үр дүн, үр нөлөөний хяналт шинжилгээ үнэлгээ хийх</li> </ul>

ХХААБ-ын чадавхийг хөгжүүлэх арга барил нь бодлогын зөвлөгөө өгөх, стратеги боловсруулах, сургах, дагалдуулан сургах, талбайн сургуулиар (ТС) сургах зэргээр дамжуулан мэргэжлийн мэдлэг, ур чадвар олгоход техникийн туслалцаа үзүүлэх явдал юм.

## 4. ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ

Нөхцөл байдлын шинжилгээний дүнд суурилан НҮБХТХ ба Засгийн газраас хүнс, хөдөө аж ахуй, байгалийн нөөцийн талаар баримтлах бодлоготой уялдуулан МХЗ-ын биелэлт болон Монгол Улсад хэрэгжүүлж буй хөтөлбөр төслийн хүрээнд олсон ололт амжилтыг харгалзан үзэж ХХААБ-аас Монгол Улсад ирэх таван жилд дараах дөрвөн тэргүүлэх чиглэлд үйл ажиллагаа явуулахаар тодорхойлов. Үүнд:

**Тэргүүлэх чиглэл 1:** Малын чанар, эрүүл мэнд, ашиг шимийг сайжруулж бэлчээр, тэжээл, усны хангамжийг нэмэгдүүлэх замаар мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх.

**Тэргүүлэх чиглэл 2:** Байгаль орчинд ээлтэй технологи, усалгаа, сэлгээний дэвшилтэт технологи нэвтрүүлж таримлын төрөл зүйлийг олшруулан газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих.

**Тэргүүлэх чиглэл 3:** Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд дасан зохицож даван туулах, удирдах зорилгоор байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хөгжүүлэх.

**Тэргүүлэх чиглэл 4:** Нэмүү өртөгийн сүлжээ бий болгох: хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын стандарт, маркетингийг сайжруулах.

Дээрх зорилгонд хүрэхэд МУЗГ-ын хөдөө аж ахуй, загас, ой, байгалийн нөөцийн асуудал эрхэлсэн яам, агентлаг, газар болон хөдөөгийн хөгжлийн холбогдох салбар, хандивлагчид, НҮБ-ын байгууллагууд, хувийн хэвшил, ИНБ, ТББ-тай хамтран ажиллана. Мөн тогтвортой, үр нөлөөтэй үр дүнд хүрэхийн тулд НҮБХТХ-тэй уялдуулан НҮБ-ын Улс орныг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээ боловсруулахад баримтлах зарчмыг<sup>5</sup> дагаж мөрдөнө.

ХАХХ-ний хүрээнд хөтөлбөр төсөл хэрэгжүүлэхдээ Засгийн газрын бодлого үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй уялдах байдал, өрсөлдөх чадварыг (Хавсралт В-г үзэх) харгалзан үзэж хөтөлбөр төслийн үр шимийг хүртэгсдээс сонгогдсон байгууллага, аж ахуйд түшиглэнэ. Хүйс, хүн ам зүй, ХДХВ/ДОХ, байгаль орчны талаар чадавхи бэхжүүлэх асуудал эдгээр тэргүүлэх чиглэлийн салшгүй хэсэг байна. Эдгээрийн хүрээнд анхаарал шаардаж буй шинэ чиглэлээр хөтөлбөр төсөл хэрэгжүүлэхээс гадна өвчин хортонтой тэмцэх, бүтээмж орлогын баталгааг хангах, чанарын баталгаа стандартын зохицуулалтыг сайжруулах, хөдөө аж ахуйн өсөлтийг нөхцөлдүүлэх чиглэлээр хэрэгжсэн болон хэрэгжиж буй үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.

## ХАМТАРЧ АЖИЛЛАХ ЧИГЛЭЛҮҮД

**Тэргүүлэх чиглэл 1:** Малын чанар, эрүүл мэнд, ашиг шимийг сайжруулж бэлчээр, тэжээл, усны хангамжийг нэмэгдүүлэх замаар мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх. Эдгээр асуудлыг энэ баримт бичгийн 3.5.4 хэсэгт танилцуулсан.

Монгол Улсын мал аж ахуй нь хүн амыг хүнсээр, боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангаж экспортын орлогыг бүрдүүлдэг эдийн засгийн чухал ач холбогдолтой салбар юм. Цаашилбал мал нь нэг талаас нөхөн сэргээгдэх нөөц, нөгөө талаас Монголчуудын уламжлалт амьжиргааны үндэс юм. Иймд хөдөө аж ахуйн салбарын дотор мал аж ахуйн салбарт илүү ач холбогдол өгч энэ үнэ цэнэтэй салбарыг хөгжүүлэх, баяжуулах улмаар уламжлалыг хадгалахын зэрэгцээ өөрчлөгдөж буй уур амьсгал, нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлыг шуурхай тусгаж авах шаардлагатай. Үүний тулд Засгийн газрын байгууллагууд төр, хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ) нэвтрүүлэх шаардлагатай юм. Энэ нь мал сүрэг малчдын хувийн өмчлөлд, байгалийн нөөц төрийн өмчлөлд байгаа өнөөгийн нөхцөлд бүрэн боломжтой.

**Зорилт 1.1** Үндэсний мал эмнэлэг, үржлийн байгууллагуудын мэргэжлийн болон менежментийн чадавхийг олон улсын стандартанд хүргэх

**Үр дүн 1.1.1** Төрийн өмчит аж ахуй (ТӨАА), сумын Мал эмнэлэг, үржлийн тасгийн мэргэжлийн болон менежментийн чадавхийг сайжруулна.

<sup>5</sup> Дэлгэрэнгүй мэдээлэл үзэх хаяг: <http://www.undg.org/index.cf?P=220>.



**Үр дүн 1.1.2** Аймаг, сумын мал эмнэлгийн лабораторийн оношлогооны чадавхийг сайжруулна.

**Зорилт 1.2** Монгол малын чанарыг сайжруулах

**Үр дүн 1.2.1** Мал аж ахуйн салбарт ТХХТ байгуулах эрх зүй, санхүүжилтийн орчин бий болгох нотолгоонд суурилсан зөвлөмж боловсруулна.

**Үр дүн 1.2.2** Малыг удмын сангийн чадавхийг сайжруулж сайн үүлдрийн малын гүн хөлдөөсөн үр, хөврөл үр бэлтгэн газар тариалангийн бүс, хот орчмын эрчимжсэн мал аж ахуйд ашиглах нөхцөл бүрдүүлнэ.

**Зорилт 1.3** Мал эмнэлгийн ажил, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах

**Үр дүн 1.3.1** Мал аж ахуйн үйлдвэрлэлд ариун цэвэр, эрүүл ахуй, халдваргүйжлэлтийн орчин үеийн арга технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

**Үр дүн 1.3.2** Мал эмнэлгийн ариутгал халдваргүйжүүлэлтийн орчин үеийн технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

**Үр дүн 1.3.3** Хил дамжин халдварладаг малын халдварт өвчний хяналтын тогтолцоог бэхжүүлнэ.

**Тэргүүлэх чиглэл 2:** Байгаль орчинд ээлтэй технологи түүн дотор усалгаа, сэлгээний дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжиж бүтээмжийг нэмэгдүүлэн хүнсний шим тэжээллэг чанарыг сайжруулах.

Монгол Улс улаанбуудай, төмсний хэрэгцээгээ дотоодын үйлдвэрлэлээрээ бүрэн хангадаг бөгөөд экспортлох боломжтой. Харин хүнсний ногооны нийт хэрэгцээнийхээ гуравны хоёр хувийг дотоодын үйлдвэрлэлээрээ хангадаг. Ургамал ургах хугацаа богино (95-110 хоног), ган гачиг тогтмол тохиолддог учир усалгаатай тариаланг өргөжүүлэх шаардлагатай. Газар тариаланг тогтвортой эрхлэхийн тулд орчин үеийн байгаль орчинд ээлтэй техник технологи ашиглах, үйлдвэрлэлийн бүтээмжийг салбарын хэмжээнд нэмэгдүүлэх, хөрс хамгаалж сайжруулах, шим тэжээл ихтэй таримлын төрлийг олшруулах, эрдэм шинжилгээ, боловсон хүчний чадавхийг сайжруулах шаардлагатай.

**Зорилт 2.1** Хөрсний үржил шимийг сайжруулах

**Үр дүн 2.1.1** Тариалангийн газрыг элэгдэл доройтлоос хамгаалах чадавхи сайжирч ойн зурвас байгуулах, дэвшилтэт техник технологи ашиглах, салхины хамгаалалт байгуулах талаар зөвлөмж боловсруулна.

**Үр дүн 2.1.2** Органик ба бусад төрлийн бордооны үйлдвэрлэл, зохистой хэрэглээг нэмэгдүүлэх зөвлөмж боловсруулна.

**Зорилт 2.2** Усалгаатай тариалан эрхлэх арга технологийг боловсронгуй болгох.

**Үр дүн 2.2.1** Одоо ашиглагдаж байгаа усалгааны технологийг сайжруулах судалгаа хийж зөвлөмж боловсруулна.

**Үр дүн 2.2.2** Орхон, Сэлэнгэ, Хэрлэн голын хөндийд усалгааны систем, комплекс байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

**Зорилт 2.3** Таримлын төрөл зүйлийг олшруулж хүнсний үйлдвэрлэл, шим тэжээллэг чанарыг нэмэгдүүлэх

**Үр дүн 2.3.1** Улсын хэмжээнд тариалдаг үр тарианы төрлийг (хөх тариа, арвай, эрдэнэ шиш г.м.) нэмэгдүүлэх чиглэлээр нотолгоонд суурилсан зөвлөмж, гарын авлага боловсруулна.

**Үр дүн 2.3.2** Хүнсний ногоо, жимс жимсгэнэ (чацаргана) үйлдвэрлэх, боловсруулах нотолгоонд суурилсан зөвлөмж бэлтгэнэ.

**Үр дүн 2.3.3** Чихрийн манжин, тосны ургамал зэрэг техникийн таримал тариалах тухай нотолгоонд суурилсан зөвлөмж боловсруулна.

**Зорилт 2.4** Газар тариалангийн үйлдвэрлэл, бүтээмжийг нэмэгдүүлэхэд дэвшилтэт арга технологи ашиглах

**Үр дүн 2.4.1** Бодлогын ба үйлдвэрлэлийн түвшинд төрийн байгууллага болон фермерүүдийн үр үржүүлэх, үйлдвэрлэх чадавхийг сайжруулна.

**Үр дүн 2.4.2** Жижиг аж ахуйд тохиромжтой механикжуулалтын төсөл хэрэгжүүлнэ.

**Тэргүүлэх чиглэл 3:** Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд дасан зохицож даван туулах, удирдах зорилгоор байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хөгжүүлэх

Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, байгалийн гаралтай цэвэр бүтээгдэхүүн, аюулгүй хүнс үйлдвэрлэхэд ус, газар болон байгалийн бусад нөөцийг ашиглахдаа даацанд нь тохируулж зохистой ашиглах шаардлагатай. Ойн дагалт баялаг, самар, жимс жимсгэнэ, мөөг, эмийн ба нарийн боовны жоронд ордог ургамлууд, газар тариалангийн бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар боловсруулж хүнсэнд хэрэглэх явдал хангалтгүй байна. Байгалийн нөөцийн менежмент, чадавхийг сайжруулах ажлын шинжлэх ухааны үндэслэлийг таниулах, мэдээлэл түгээх сүлжээ ажиллуулж энэ ажлын үр дүн, үр өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагатай. Байгаль орчны менежмент, зохион байгуулалт, шинэчлэл, чадавхижуулах болон байгаль хамгаалах түүнчлэн цөлжилтийг бууруулах, байгалийн нөөцийг доройтлоос хамгаалахад төр, олон нийт, аж ахуйн нэгж, бусад байгууллагын оролцоо, үүрэг хариуцлагыг сайжруулах зорилгоор нэн тэргүүнд хийх ажил, хүрэх үр дүнг тодорхойлсон.

Дээр дурдсанчлан Монгол орны мал аж ахуй, газар тариалангийн салбар ган, зуд гэх мэт байгалийн гамшигт өртөмтгий. Сүүлийн үед уур амьсгалын өөрчлөлтийн улмаас иймэрхүү байгалийн гамшигийн давтамж ойртож, удаан үргэлжилдэг, улам хор хөнөөлтэй болж байгаа. Энэ хоёр байгалийн гамшиг харилцан холбоотой бөгөөд хүнс, хөдөө аж ахуй, байгалийн нөөцийн салбарт бүхэлд нь сөргөөр нөлөөлдөг. Үүний улмаас хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг уур амьсгалын өөрчлөлтөнд зохицуулах, түүний сөрөг нөлөөлийг бууруулах, байгалийн гамшиг болсон үед даван туулах, эрсдэл даах зохистой арга механизм, бүтцийг нэвтрүүлэх шаардлага бий болж байна.

Монгол Улсын хөдөө аж ахуйн үйлдвэрлэл үндсэндээ ТХХТ-д тулгуурладаг бөгөөд үйлдвэрлэлийн өмч хөрөнгө нь хувийн өмч, харин бэлчээр, тариалангийн газар төрийн өмч байгаа. Малчид, тариаланчид хувийн мал, газар тариалангийн үйлдвэрлэлээ хариуцах үүрэгтэй, төр бодлогын орчин бүрдүүлэх, байгалийн нөөцийг тогтвортой байлгах, онц байдал үүссэн үед яаралтай тусламж үзүүлэх үүрэгтэй.

Эдгээр хүчин зүйлсийг харгалзан үзэхэд байгалийн гамшигийн үед хариу арга хэмжээ авах, даван туулахад урьдчилан сэргийлэх мэдээ, бэлэн байдал, үнэлгээ, аврах ба сэргээн босгох арга хэмжээний мэдээллийн сүлжээ байгуулах, гамшигийн эсрэг ажиллах байгууллагуудын хууль эрх зүйн орчин, техник тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах, эрсдлийн менежментэнд хамтын хөрөнгө оруулахад үндэсний ба орон нутгийн түвшинд бүх оролцогч талын хүчин чармайлтыг нэгтгэх шаардлагатай.

**Зорилт 3.1** Гамшигийн эрсдлийг бууруулах, эрт мэдээлэх замаар хүн амын хүнс, тэжээлийн баталгаат байдлыг (ХТББ) сайжруулах

**Үр дүн 3.1.1** Хүнс, тэжээлийн баталгаат байдлыг хангах зорилгоор гамшигийн эрсдлийг бууруулах бодлого, зохицуулалтын хүрээг бий болгоно.

**Үр дүн 3.1.2** Нэгдсэн мэдээллийн сүлжээ, эрт мэдээлэх тогтолцоог бий болгоно.

**Зорилт 3.2** Хамтын оролцоотой ойн менежментийг хөгжүүлэх

**Үр дүн 3.2.1** БОНХЯ, Ойн газар, аймгуудын Ойн ангийн хамтын оролцоотой ой, загас, ан амьтдын менежментийн чадавхийг сайжруулна.

**Үр дүн 3.2.2** Ойн газрын чадавхийг бэхжүүлж ан амьтдын менежмент, хамгаалалтыг сайжруулна.

**Үр дүн 3.2.3** Ой, загас, ан амьтдын нөхөрлөлийн (шинэ, хуучин) чадавхийг сайжруулна.

**Зорилт 3.3** Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх үндэсний чадавхийг сайжруулах

**Үр дүн 3.3.1** Ой хамгаалах төвийн чадавхийг бэхжүүлж ойн тооллого хийнэ.

**Үр дүн 3.3.2** Ойн хамгаалах төвийн чадавхийг бэхжүүлж ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх мэдээллийн сүлжээ бий болгоно.

**Үр дүн 3.3.3** Ойн хөнөөлт шавьж хортон устгах байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлнэ.

**Үр дүн 3.3.4** Модны үр бэлтгэх, тарьц суулгац бойжуулах арга технологи, техник тоног төхөөрөмжийг боловсронгуй болгож ойг нөхөн сэргээх арга барилыг сайжруулж ойжуулах ажлын чанар, үр дүнг нэмэгдүүлнэ.



**Зорилт 3.4** Загасны нөөцийн тогтвортой менежментийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох

**Үр дүн 3.4.1** Монгол орны бүх төрлийн загасны нөөцийг тогтоох судалгаа хийх эрдэм шинжилгээний байгууллагуудын чадавхийг сайжруулна.

**Үр дүн 3.4.2** БОНХЯ, ҮХААЯ-нд зохиомол орчинд загасны аж ахуй эрхлэх, загас үржүүлэх талаар нотолгоонд суурилсан бодлогын зөвлөгөө өгнө.

**Зорилт 3.5** Мал аж ахуйн салбарын уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд дасан зохицох чадавхийг сайжруулах

**Үр дүн 3.5.1** Малчдын уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох чадавхийг сайжруулна.

**Үр дүн 3.5.2** Орон нутгийн түвшинд тэжээл үйлдвэрлэх орчин үеийн арга технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж нотолгоонд суурилсан зөвлөмж боловсруулна (ХХААБ-ын туршилтын хөтөлбөрийг өргөжүүлэх замаар).

**Үр дүн 3.5.3** Малын (хонь, ямаа) хашаа хорооны чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлж загвар хашааны нотолгоонд суурилсан зөвлөмж боловсруулна.

**Үр дүн 3.5.4** Аймаг дундын отрын бүс нутагт ТХХТ-ээр бэлчээр, уст цэгийн тогтвортой менежмент бий болгоно.

**Тэргүүлэх чиглэл 4:** Нэмүү өртгийн сүлжээ бий болгох: хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын стандарт, маркетингийг сайжруулах.

Шилжилтийн эхэн үед төрийн худалдаа бэлтгэлийн тогтолцоо болон хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдийг хувьчилснаас хойш үйлдвэрлэгч, боловсруулагч, эцсийн хэрэглэгчийн хоорондох найдвартай бэлтгэл, борлуулалтын сүлжээ байхгүй болж хот хөдөөгийн хүн амын хүнсний хэрэглээнд огцом ялгаа гарч хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн чанар муудаж үйлдвэрлэгчдийн орлого буурч үндэсний үйлдвэрүүд түүхий эдээр дутагдаж, боловсруулаагүй түүхий эд экспортонд гаргадаг болсон. Иймд анхан шатны үйлдвэрлэгчдийг хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулдаг үйлдвэр, эцсийн хэрэглэгчтэй холбодог найдвартай маркетингийн сүлжээ бий болгох шаардлагатай.

Монгол Улсад хүнсний бүтээгдэхүүнийг нэг бол дотооддоо үйлдвэрлэж, тодорхойгүй тээврээр тээвэрлэж зах зээлд хүргэдэг эсвэл жижиг наймаачид импортоор оруулж ирдэг тухай нөхцөл байдлын шинжилгээнд товч танилцуулсан. Ийм гарал үүсэл тодорхойгүй, чанар, эрүүл ахуйн гэрчилгээгүй бүтээгдэхүүнийг хүний хэрэглээнд нийлүүлж хүнс, хүний аюулгүй байдлыг алдагдуулж байгаа. Иймд төр, хувийн хэвшил аль аль нь хүнсний бүтээгдэхүүнд зохих өртөг нэмэх сүлжээ байгуулж хүнсний үйлдвэрлэлийг шинэчилэн өргөжүүлж хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоог боловсронгуй болгох хэрэгтэй. Үүний тулд нэмүү өртөг бүтээн хүнсний чанар, аюулгүй байдлын стандартыг сайжруулан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах болон ЖДҮ-ийг дэмжиж үйлдвэрлэгчдэд зах зээлд нэвтрэх боломж бүрдүүлэх зэрэг цогц арга хэмжээ авах шаардлагатай.

Хүнсний үйлдвэрлэлд ЭЦЭХ болон бусад стандартуудыг нэвтрүүлж аюулгүй байдлын менежмент, хяналтын тогтолцоог сайжруулах замаар хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсээр дамжин халдварлах өвчнөөс урьдчилан сэргийлэх, шим тэжээл, нийгмийн эрүүл мэндийг сайжруулах, ХАА-н гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх юм.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн олонхи нь өрхийнхөө хэрэглээг хангах төдий үйлдвэрлэл эрхэлдэг, өөр орлогын эх үүсвэргүй малчид, тариаланчдын жижиг аж ахуй байдаг. Тэд байгалийн гамшигт өртөмтгий, хөдөөнөөс хотод нүүж ирэгсдийн ихэнхи хувийг бүрдүүлдэг. Арилжааны банк, бичил санхүүгийн байгууллагууд ХАА-н үйлдвэрлэгчдэд, ялангуяа малчдад барьцааны хөрөнгө хангалтгүй гэсэн шалтгаанаар зээл олгох сонирхолгүй байдаг. Иймд бичил санхүүг, тоног төхөөрөмжийн лизинг, даатгалын үйлчилгээ, сургалт хийх, ХАА-н бус ажлын байр бий болгоход туслах экстеншиний үйлчилгээ гэх мэт өөр бусад үйлчилгээг бий болгох механизм бүрдүүлэх хэрэгтэй.

Дан ганц хөдөө аж ахуйгаас орлого олдог, байгалийн гамшигт хамгийн өртөмтгий жижиг фермер, хөдөөгийн ядуу өрхийг дэмжих хүнсний баталгаат байдлын цогц бодлого, стратеги, холбогдох хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулах шаардлагатай байна. Монгол Улсын Засгийн газар хоршооллыг хөгжүүлж хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж хөдөөд ядуурлыг

бууруулах зорилготой “Хоршоо хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-2”-ийг 2009-2017 онд хэрэгжүүлж байна.

**Зорилт 4.1** Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэл ба нэмүү өртөгийн сүлжээ бий болгох

**Үр дүн 4.1.1** Хөдөө аж ахуйн хоршоодын чадавхийг сайжруулж хураалтын дараах алдагдлыг бууруулах

**Үр дүн 4.1.2** Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд (сүү) боловсруулах ЖДҮ-ийн хүчин чадлыг нэмэгдүүлж малчид, ногоочдын чадавхийг бэхжүүлнэ.

**Зорилт 4.2** Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг сайжруулах

**Үр дүн 4.2.1** Олон улсын чанар, аюулгүй байдлын стандартанд хүрсэн хүнс үйлдвэрлэж Монгол хүнсний өрсөлдөх чадвартай брэндүүд бий болгоход дэмжлэг үзүүлнэ.

**Үр дүн 4.2.2** Хүнсний үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөх эрх зүйн ба хүнсний аюулгүй байдлын менежментийн хүрээ бий болгоход дэмжлэг үзүүлнэ.

## 5. ТААМАГЛАЛ БА ЭРСДЛҮҮД

Дараах нөхцөл байдалд ХАХХ-ний зорилго зорилтонд хүрэх боломжтой гэж тооцоолсон. Үүнд:

- Хөдөө аж ахуйд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх Засгийн газрын тааламжтай бодлого, чин хүсэл хэвээр үргэлжилж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ тус салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нөхцөл болох
- Энх тайван, тогтвортой байдал үргэлжилж уур амьсгал ба цаг агаарын тааламжтай нөхцөл давамгайлах
- Эрчим хүчний үйлдвэрлэл, түгээлт сайжирч хамрах хүрээ нь тэлэх
- Дотоод, гадаадын зах зээлд түлшний үнэ, зээлийн хүү тогтвортой байх
- Хандивлагчид, хөгжлийн түншүүд, НҮБ-ын байгууллагууд, төвийн ба орон нутгийн засаг захиргаа, ТББ зэрэг түнш байгууллагууд үйл ажиллагааг хамтарч хэрэгжүүлэх, санхүүжүүлэх
- Хандивлагчдын санхүүжилт үргэлжлэн нэмэгдэж, онцгой байдлын санхүүжилтээс томоохон хөтөлбөрүүдийг санхүүжилтэд аажмаар шилжих
- ХАХХ-ийг хэрэгжүүлэхэд ХХААБ, Засгийн газар төсвөөс гадуурх эх үүсвэрүүдийг дайчлах

## 6. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Тусламж, хөгжлийг үр өгөөжтэй байлгах олон улсын зөвшилцлийн дагуу ХАХХ нь Монгол Улсын Засгийн газар ба ХХААБ-ын хамтын өмч бөгөөд ХАХХ-ийг хэрэгжүүлэх, зохицуулах механизмыг энэ зарчмын үндсэн дээр боловсруулсан.

ХХААБ нь МУЗГ-тай удаан хугацаанд хамтран ажиллаж хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх замаар өлсгөлөн, хоол тэжээлийн дутагдал, ядуурлыг бууруулахад оролцсон. Мөн байгаль орчныг хамгаалах, тогтвортой хөгжлийг сурталчилах, гамшгийн эрсдлийг даван туулах менежментийг нэвтрүүлэхэд МУЗГ-тай идэвхитэй түншилдэг юм. Монгол Улсад 2009 онд зуд болж 9.2 сая толгой мал хорогдсоны дараа Техникийн туслалцааг зохицуулах төслийн нэгж (ТТЗТН) байгуулсан. ХХААБ-аас Монгол Улсад онцгой байдлын хөтөлбөр хэрэгжүүлж зуданд нэрвэгдсэн малчдын үлдсэн малыг хамгаалах чиглэлээр шууд туслалцаа үзүүлсэн.

ХХААБ-ын ажил, үйлчилгээ тухайлбал техникийн туслалцаа үзүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх, мэдлэг дамжуулах, бодлогын зөвлөгөө өгөх, төвийг сахисан форум зохион байгуулах, хувийн хэвшил, ТББ-уудтай түншлэл байгуулах, гадаад эх сурвалжийг дайчлах зэрэг нь даяаршил, чөлөөт зах зээлийн өөрчлөлтөнд шуурхай хариулахад чухал ач холбогдолтой. ХАХХ-ийг хэрэгжүүлэх явцад эдгээр ажил үйлчилгээгээ үзүүлнэ.

ХАХХ-ийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд үндэсний Удирдах хороо ба Техникийн зөвлөл байгуулна. Удирдах хороо нь ХАХХ-ийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулах, бодлогын шийдвэр гаргах байгууллага бөгөөд ҮХААЯ-ны төрийн нарийн бичиг дарга удирдаж гишүүд нь холбогдох яам, газар, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл байна. Ажлын хэсгийн түвшинд ХАХХ-ний Техникийн хороо байгуулж ҮХААЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга удирдах ба гишүүд нь ҮХААЯ, БОНХЯ, ХХААБ, холбогдох яам, байгууллагуудын төлөөлөл байна.

Техникийн хороо ХАХХ-ний Удирдах хороонд ажлаа тайлагнаж ХАХХ-ний хэрэгжилтийн талаар бодлогын шийдвэр гаргаж шаардлагатай болбол батлагдсан ажлын төлөвлөгөө, хүрээний дагуу асуудлыг ХАХХ-ний Удирдах хороонд өргөн барина. ХАХХ-ний Техникийн хорооны уулзалтыг хагас жилд нэг удаа зохион байгуулах ба ээлжит бус уулзалтыг хорооны даргын шийдвэрээр зарлана.

Техникийн хороо жил бүр ХАХХ-ний хэрэгжилтийг тайлагнах семинар зохион байгуулж ХАХХ-ний хэрэгжилтийн тайлан боловсруулж Удирдах хороогоор батлуулна. ХАХХ-ний бичиг баримтанд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай болбол Удирдах хорооны гишүүд, холбогдох яам газрын төлөөлөгчдийг оролцуулан гүйцэтгэнэ. Семинарт ИНБ, боловсролын ба эрдэм шинжилгээний байгууллагууд, мэргэжлийн холбоодыг идэвхитэй оролцуулахыг зорино.

## **7. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ**

Явцын хяналт хийж үнэлгээний дүн гаргах нь гүйцэтгэлд суурилсан менежментийн үндсэн үйл ажиллагаа юм. ХШҮ-ний тогтолцооны давуу тал нь гүйцэтгэлийн талаар хангалттай мэдээлэл авч улмаар түүнд тулгуурлан үр дүнгийн менежмент хийж гүйцэтгэлийг сайжруулж болдогт оршдог. ХШҮ-ний тогтолцоог төслийн ажилтан, түнш, хамтрагч, үйлчлүүлэгч, эцсийн үр шимийг хүртэгч, хандивлагч болон засгийн газар хэрэглэж болно. Иймээс гүйцэтгэлийг хянах сайн тогтолцоо бүрдүүлэхийн тулд төслийн бүх оролцогч тал үнэлгээгээр ямар зүйлд зорьж байгааг харилцан ойлголцож хүлээн зөвшөөрсөн байх хэрэгтэй.

ХАХХ-ний нэг хэсэг нь хяналт шинжилгээ үнэлгээний хүрээ байх бөгөөд ХАХХ-ний хэрэгжилтийг хянах удирдамжийг НҮБХТХ-ийг баримтлан боловсруулсан. Засгийн газар, ХХААБ, хөгжлийн түнш, үр шим хүртэгчид жил бүрийн ажлын төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийг хамтран хэлэлцэх болон газар дээр нь очиж танилцах замаар хяналт шинжилгээг гүйцэтгэнэ. ХХААБ-аас Ром дахь төв байгууллага, Бангкок дахь Бүсийн төв, Монгол Улс дахь шадар суурин төлөөлөгчийн газрын төлөөлөлтөй салбар дундын ажлын хэсэг байгуулж ХАХХ-ний гүйцэтгэлийг хянана. Үүнээс гадна итгэлцлийн сангаас хэрэгжих төслийн хувьд засгийн газар, хандивлагч, ХХААБ-ын Үнэлгээний албанаас төлөөлөлтөй баг гарч бие даасан үнэлгээ хийнэ.

## **8. ШААРДАГДАХ НӨӨЦ БА НӨӨЦИЙГ ДАЙЧЛАХ СТРАТЕГИ**

ХХААБ нь ХАХХ-ний үйл ажиллагааг тал бүрээс нь сурталчилах үүрэг хүлээдэг бөгөөд энэ үүргээ хэрэгжүүлэхэд бүх хүчээ дайчлан ажиллахын зэрэгцээ хөтөлбөрийн зорилго зорилтыг биелүүлэхэд шаардагдах нөөцийг тогтоож түүнийг бүрдүүлэх ажлыг гүйцэтгэдэг. Хандивлагчид санхүүгийн асуудалд орох зэргээр эх үүсвэр хязгаарлагдах тохиолдол үүсвэл Засгийн газартай хамтран өөр эх үүсвэр хайх ажлыг гүйцэтгэнэ.

ХАХХ-ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн хэмжээг тэргүүлэх чиглэлээр тоймлон Хавсралт В-д үзүүлсэн.

## 9. ХАВСРАЛТУУД

### Хавсралт А: ХАХХ-НИЙ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХҮСНЭГТ

2012-2016 оны ХАХХ-ний тэргүүлэх чиглэл	Монгол Улсын Засгийн газрын дунд хугацааны хөтөлбөрүүдтэй холбогдох байдал	2012-2016 оны НҮБХХТХ-тэй холбогдох байдал	Үндэсний МХЗ-той холбогдох байдал	ХХААБ-ын Стратегийн зорилт (СЗ) ба Бүс нутгийн тэргүүлэх чиглэлтэй (БНТЧ) холбогдох байдал
<p><b>ХАХХ-ний тэргүүлэх чиглэл 1:</b> Малын чанар, эрүүл мэнд, ашиг шимийг сайжруулж бэлчээр, тэжээл, усны хангамжийг нэмэгдүүлэх замаар мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх.</p>	<p>Монгол мал хөтөлбөрийн зорилт: Уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн хөгжилтэй дасан зохицсон хөдөө аж ахуйг хөгжүүлж мал аж ахуйн салбарыг эдийн засгийн хувьд үр ашигтай, зах зээлд өрсөлдөх чадвартай болгох орчин бүрдүүлэх, хүн амыг эрүүл аюулгүй хүнсээр, үйлдвэрийг түүхий эдээр хангах, экспортлох.</p>	<p><b>Тэргүүлэх чиглэл 1:</b> Эдийн засгийг тогтвортой өсгөж ядуурлыг бууруулах (Ядуурлыг бууруулахад эдийн засгийн хөгжил зойлшгүй шаардлагатай).</p> <p><b>Зорилт 1:</b> Амьжиргаагаа сайжруулах боломж ялангуяа ядуу ба эмзэг бүлгийн хүмүүст олгох.</p>	<p><b>Ядуурал өлсгөлөнг арилгах:</b> 1990-2015 онд ядуу амьдарч байгаа хүмүүсийн тоог 50% бууруулах. 1990-2015 онд өлсгөлөн амьдарч байгаа хүмүүсийн тоог 50% бууруулах.</p> <p>Ядуурлыг 18 хувиас бууруулах.</p>	<p>Б) Мал аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх (СЗ) Б) ХАА-н үйлдвэрлэл, хөдөөгийн хөгжлийг нэмэгдүүлэх (БНТЧ)</p>
<p><b>ХАХХ-ний тэргүүлэх чиглэл 2:</b> Байгаль орчинд ээлтэй технологи, усалгаа, сэлгээний дэвшилтэт технологи нэвтрүүлэн таримлын төрөл зйлийг олшруулж газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих.</p>	<p><b>МХЗ-д суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого:</b> (а) Газар ашиглалтыг сайжруулах, усалгаатай тариалан эрхлэх, биотехнологи нэвтрүүлэх замаар газар тариалангийн үйлдвэрлэлийг өсгөх, (б) Газар тариаланд хөрсийг элэгдлээс хамгаалах, үржил шимийг нь хадгалах, чийгийн алдагдлыг бууруулах дэвшилтэт технологи нэвтрүүлэх.</p>			<p>А) Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой эрчимжүүлэх (СЗ) Б) Мал аж ахуйн үйлдвэрлэл, хөдөөгийн хөгжлийг нэмэгдүүлэх (БНТЧ)</p>

<p><b>ХАХХ-ний тэргүүлэх чиглэл 3:</b> Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд дасан зохицож даван туулах, удирдах зорилгоор байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хөгжүүлэх.</p>	<p>МХЗ-д суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого:</p> <ul style="list-style-type: none"> <li>■ Ой мод: ойн нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, экологийн тэнцвэрийг хадгалах нөхцөл бүрдүүлэх.</li> <li>■ Ан амьтан: амьтан, ургамлын хорогдлыг зогсоох, байгалийн жамаар нөхөн сэргээх, тогтвортой ашиглах нөхцлийг бүрдүүлэх, ховор нэн ховор зүйлүүдийн байгалийн ба тогтвортой өсөлтийг хангах холбогдох дүрэм журмыг сайжруулах.</li> <li>■ МУЗГ 2008 онд агнуурын загас хамгаалах, үржүүлэх үндэсний хөтөлбөр баталсан. Энэ хөтөлбөрийн зорилт нь агнуурын загасны нөөцийг хамгаалах, хэвийн өсөлтийг нь хангах, загас агнуурын аж ахуйн бүтэц зохион байгуулалт, менежментийг шинэ түвшинд гаргах, цэнгэг усны загас үржүүлэх, загасан бүтээгдэхүүний тоо төрлийг олшруулах.</li> <li>■ Энэ асуудал МУЗГ-ын ихэнхи хөтөлбөрт тусгагдсан (Монгол мал, Малын тэжээл, Атрын III хөтөлбөр г.м.). Гэвч ТХХТ-д суурилан хөрс хамгаалах, сайжруулах, бэлчээр, тариалангийн газар усжуулах, байгалийн гамшигт өртөмтгий байдлыг бууруулахад таримлын даатгалын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.</li> </ul>	<p><b>Тэргүүлэх чиглэл 3:</b> Байгаль орчин, уур амьсгалыг өөрчлөлт, гамшгийн эрсдлийг бууруулах (Байгалийн нөөцийн менежмент сайжирч экосистем ба уур амьсгалын өөрчлөлтөнд эмзэг бүлгийн эрсдэл даах чадвар нь нэмэгдэнэ).</p> <p><b>Зорилт 7.</b> Нөөцийн тогтвортой менежментэнд анхан шатны хэрэглэгчдийг оролцуулж боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх.</p> <p><b>Зорилт 8.</b> Байгалийн ба хүний үйл ажиллагаанаас үүссэн гамшгийн эрсдэл, үр дагаврыг үндэсний ба орон нутгийн түвшинд бууруулах.</p> <p><b>Зорилт 9.</b> Эрчим хүч хэмнэх, ногоон аж ахуй хөгжүүлэх хот суурин газрын агаарын бохирдлыг бууруулах.</p>	<p><b>МХЗ 7:</b> Байгаль орчны тогтвортой байдлыг хангах.</p> <p>Тогтвортой хөгжлийн зарчмуудыг улс орны бодлого, хөтөлбөрүүдэд тусгах, хот суурин газар ялангуяа Улаанбаатар хотод агаарын бохирдлыг бууруулах.</p> <p>Гол, горхины ундаргыг нөхөн сэргээх замаар хатаж алга болох явдлыг бууруулах.</p> <p>2015 гэхэд ундны усны найдвартай эх үүсвэр, ариун цэврийн үндсэн нөхцөл бүрдсэн орчинд амьдрах хүмүүсийн тоог нэмэгдүүлэх.</p>	<p>В) Загас, гол мөрний нөөцийн тогтвортой менежмент ба ашиглалт (СЗ)</p> <p>Д) Ой модны тогтвортой менежмент (СЗ)</p> <p>Е) Газар, ус, генетикийн нөөцүүдийн тогтвортой менежмент ба хүнс ХАА-н салбарт үүсэх байгаль орчны асуудлуудыг шийдвэрлэх (СЗ)</p> <p>В) Байгалийн нөөцийн менежмент, ашиглалтыг тогтвортой, үр дүнтэй эрхлэх (БНТЧ)</p> <p>З) Хүнс, Хөдөө аж ахуйн салбарт үүсч болох асуудал, онц байдалд бэлэн байх, хариу арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэх (СЗ)</p> <p>В) Хүнс, хөдөө аж ахуйн салбарт үүсч болох асуудал, онц байдалд хариу өгөх боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх (БНТЧ)</p>
---	---	--	---	--

<p>ХАХХ-ний тэргүүлэх чиглэл 4: Нэмүү өртгийн сүлжээ бий болгох: хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын стандарт, маркетингийг сайжруулах.</p>	<p>2012 оны 6 сарын 1-нээс мөрдөгдөж эхэлсэн ХАА-н бараа түүхий эдийн биржийн тухай хуулиар хүнсний чанар, аюулгүй байдлын стандартуудыг сайжруулах, нэмүү өртөг шингээсэн борлуулалтын механизм бий болгох, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнийг зохистой тогтоох замаар малчид тариаланчдын олох орлогыг нэмэгдүүлэх юм.</p> <p>ХБҮҮХ-т хүнсний хангамж, чанар, аюулгүй байдлыг хамгаалах хууль, эдийн засаг, зохион байгуулалтын орчинг сайжруулах, гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор эдийн засаг, санхүү, бизнесийн орчин бий болгох асуудлыг авч үзсэн.</p>	<p><b>Тэргүүлэх чиглэл 1:</b> Эдийн засгийг тогтвортой өсгөж ядуурлыг бууруулах (Ядуурлыг бууруулахад эдийн засгийн хөгжил зойлшгүй шаардлагатай).</p> <p><b>Зорилт 2.</b> Ядуурлыг бууруулах бодлого, стратеги боловсруулах.</p>	<p><b>МХЗ 8</b> - Хөгжлийн түншүүдтэй болох.</p> <p>Худалдаа, санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх замаар МХЗ-уудыг биелүүлэх нөхцөл бүрдүүлэх.</p> <p>Мэдээлэл харилцаны шинэ технологи хөгжүүлж мэдээллийн нийгэм байгуулах.</p>	<p>Г) Хүнсний хэлхээний бүх шатанд хүнсний чанар аюулгүй байдлыг сайжруулах (СЗ)</p> <p>Ё) Амьжиргааг сайжруулж хөдөөг хөгжүүлэхэд зах зээлийн орчин бүрдүүлэх (СЗ)</p> <p>Ж) Хүнсний баталгаат байдал, шим тэжээлийн хангамж нэмэгдэнэ (СЗ)</p> <p>А) Хүнс, шим тэжээлийн баталгаат байдлыг хангах (БНТЧ)</p> <p>Л) Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжилд төр, хувийн хэвшлээс оруулах хөрөнгө оруулалтыг үр дүнтэй болгох, ихэсгэх (СЗ)</p>
---	---	---	---	--

## Хавсралт Б: ХАХХ-НИЙ ҮР ДҮНГИЙН ХҮСНЭЛТ (А ХЭСЭГ)

ХАХХ-ний үр дүн	Шалгуур үзүүлэлт, суурь ба зорилтот түвшин	Баталгаажуулах эх үүсвэр	Эрсдэл
<p><b>Зорилт 1.1</b> Үндэсний мал эмнэлэг, үржлийн байгууллагуудын мэргэжлийн болон менежментийн чадавхийг олон улсын стандартад хүргэх.</p>	<p>Мал эмнэлэг, үржлийн байгууллагуудад олон улсын стандарт нэвтрүүлнэ. Суурь: 22% (2009) Зорилт: 50%</p>	<p>МЭҮГ-ын жил бүрийн тайлан, мэдээлэл, МЭҮБ-ын тайлан</p>	<p>Зохихон байгуулж чадахгүй байх</p>
<p><b>Үр дүн 1.1.1</b> Төрийн өмчит аж ахуй (ТӨАА), сумын Мал эмнэлэг, үржлийн тасгийн мэргэжлийн болон менежментийн чадавхийг сайжруулна.</p>	<p>Үндэсний сургагч багш нарын тоо Суурь: 0 Зорилт: мал эмнэлгийн 25, мал үржлийн 25 сургагч багш Мал эмнэлэг, үржлийн тасгийн ажилтнуудыг сургана. Суурь: 0 Зорилт: бүх МЭҮТ-ийн ажилтан 670 хүн</p>	<p>МЭҮГ-ын жил бүрийн тайлан МЭҮГ-ын жил бүрийн тайлан МЭҮГ-ын жил бүрийн тайлан</p>	<p>Санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх Санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх Санхүүгийн эх үүсвэр, барилга байшин, багаж төхөөрөмж, дэд бүтэц хүрэлцэхгүй байх</p>
<p><b>Үр дүн 1.1.2</b> Аймаг, сумын мал эмнэлгийн лабораторийн оношлогооны чадавхийг сайжруулна.</p>	<p>Аттестатчилагдсан хувийн мал эмнэлэг, цөм сүргийн аж ахуйн эзлэх хувь Суурь: 22% Зорилт: &gt;50%</p>	<p>МЭҮГ-ын жил бүрийн тайлан МЭҮГ-ын жил бүрийн тайлан МЭҮГ-ын жил бүрийн тайлан</p>	<p>Санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх Санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх Санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх</p>
	<p>Аттестатчилагдсан сумын мал эмнэлгийн лабораторийн тоо Суурь: 0 Зорилт: 50</p>		
	<p>Аттестатчилагдсан аймгийн мал эмнэлгийн лабораторийн тоо Суурь: 18 Зорилт: 22</p>		
	<p>Аттестатчилагдсан хувийн мал эмнэлгийн эзлэх хувь Суурь: 22% (2010) Зорилт: 50%-иас доошгүй</p>		



## ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭ (ХАХХ) 2012-2016

<p><b>Зорилт 1.2</b> Монгол малын чанарыг сайжруулах.</p>	<p>Цөм сүргийн аж ахуй дахь чанарын сертификаттай үржлийн малын тоо Суурь: 12,161 (2011) Зорилт: 20,000</p> <p>Цэвэр ба эрлийз үүлдрийн малын тоо, '000 Суурь: 1,744.8 (2010) Зорилт: 2,270.0</p>	<p>МЭҮГ-ын жил бүрийн тайлан МЭҮГ-ын жил бүрийн тайлан</p>	<p>Зуд, байгалийн гамшиг, гоц халдварт өвчин тохиолдох Зуд, байгалийн гамшиг, гоц халдварт өвчин тохиолдох</p>
<p><b>Үр дүн 1.2.1</b> Мал аж ахуйн салбарт ТХХТ байгуулах эрх зүй, санхүүжилтийн орчин бий болгох нотолгоонд суурилсан зөвлөмж боловсруулна.</p>	<p>МАА-н үйлдвэрлэлд ТХХТ-ийг хөгжүүлэх хууль эрх зүйн хүрээ Суурь: 0 Зорилт: Мал үржлийн ажил, үйлчилгээнд мөрдөгдөх ТХХТ-ийн гэрээ, заавар, зөвлөмж</p> <p>МАА-н салбарт байгуулагдах ТХХТ-ийн тоо Суурь: 0 Зорилт: 48</p> <p>ТХХТ-ийн гэрээгээр борлуулагдах үржлийн малын тоо Суурь: 0 Зорилт: 1,200/жил</p>	<p>МЭҮГ-ын жил бүрийн тайлан МЭҮГ-ын жил бүрийн тайлан МЭҮГ-ын жил бүрийн тайлан</p>	<p>ТХХТ-ийг буруу ойлгох Санхүүгийн эх үүсвэр, барилга, багаж тоног төхөөрөмж хүрэлцэхгүй байх Санхүүгийн эх үүсвэр, барилга, багаж тоног төхөөрөмж хүрэлцэхгүй байх, халдварт өвчин гарах</p>
<p><b>Үр дүн 1.2.2</b> Малын удмын сангийн чадавхийг сайжруулж сайн үүлдрийн малын гүн хөлдөөсөн үр, хөврөл үр бэлтгэн газар тариалангийн бүс, хот орчмын эрчимжсэн мал аж ахуйд ашиглах нөхцөл бүрдүүлнэ.</p>	<p>Үр гүн хөлдөөх цех импортлох юмуу байгуулна. Суурь: Гар ажиллагаатай цех Зорилт: Автомат ажиллагаатай, ариун цэврийн шаардлага хангасан цех</p> <p>Жилд бэлтгэх гүн хөлдөөсөн үр, хөврөл үрийн тоо Суурь: 8,000 тун үр Зорилт: 100,000 тун үр, хөврөл үр</p> <p>Үржлийн технологич бэлтгэнэ. Суурь: 35 Зорилт: 150</p>	<p>МЭҮГ-ын жил бүрийн тайлан, Малын удмын сангийн тайлан МЭҮГ-ын жил бүрийн тайлан, Малын удмын сангийн тайлан МЭҮГ-ын жил бүрийн тайлан, Малын удмын сангийн тайлан</p>	<p>Санхүүгийн эх үүсвэр, үйлдвэрлэлийн байр хүрэлцэхгүй байх Санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх Байхгүй</p>



<p><b>Зорилт 1.3</b> Мал эмнэлгийн ажил, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.</p>	<p>Жилд вакцинжуулах малын тоо, '000 Суурь: 9,245.7 (2010) Зорилт: 10,632.56</p> <p>Жил бүр халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах малын тоо (давхардсан тоогоор), '000 Суурь: 30,451.7 (2010) Зорилт: 35,000.0</p> <p>Олон улсын стандартын сертификаттай оношлогооны лабораторийн тоо Суурь: 0 (2010) Зорилт: 2, хил дамжин халдварлах өвчний хувьд УМЭАЦП, бруцеллёзын хувьд МЭЭШХ</p> <p>Жил бүр лабораторийн шинжилгээ оношлогоонд хамрагдах малын тоо '000 Суурь: 1029 (2010) Зорилт: 2,000.0</p>	<p>Монгол Улсын статистикийн эмхэтгэл Монгол Улсын статистикийн эмхэтгэл МЭҮГ-ын жил бүрийн тайлан Монгол Улсын статистикийн эмхэтгэл</p>	<p>Санхүүгийн эх үүсвэр, барилга, багаж тоног төхөөрөмж, дэд бүтэц хүрэлцэхгүй байх</p> <p>Санхүүгийн эх үүсвэр, багаж тоног төхөөрөмж, дэд бүтэц хүрэлцэхгүй байх</p> <p>Санхүүгийн эх үүсвэр, барилга, багаж тоног төхөөрөмж, дэд бүтэц хүрэлцэхгүй байх</p> <p>Санхүүгийн эх үүсвэр, барилга, багаж тоног төхөөрөмж, хувийн мал эмнэлгүүдэд хөргүүр хүрэлцэхгүй байх</p>
<p><b>Үр дүн 1.3.1</b> Мал аж ахуйн үйлдвэрлэлд ариун цэвэр, эрүүл ахуй, халдваргүйжүүлэлтийн орчин үеийн арга технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>Ариун цэвэр, эрүүл ахуй, халдваргүйжүүлэлтийн үндэсний стандартууд боловсруулна. Суурь: 300 Зорилт: 320</p> <p>Үндэсний стандартуудыг мөрддөг эрчимжсэн аж ахуйн тоо Суурь: 1,662 аж ахуйн 19 нь Зорилт: 2,500 аж ахуйн 500 нь</p> <p>Сертификаттай мал аж ахуйн фермийн тоо Суурь: 0 Зорилт: 10</p>	<p>Стандарт хэмжил зүйн үндэсний төвийн тайлан МЭҮГ-ын жил бүрийн тайлан МЭҮГ-ын жил бүрийн тайлан</p>	<p>Зохион байгуулалтын уялдаа холбоо хангалтгүй байх</p> <p>Санхүүгийн эх үүсвэр, менежмент хангалтгүй байх</p> <p>Санхүүгийн эх үүсвэр, менежмент хангалтгүй байх</p>

## ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭ (ХАХХ) 2012-2016

<p><b>Үр дүн 1.3.2</b> Мал эмнэлгийн ариутгал халдваргүйжүүлэлтийн орчин үеийн технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ (үлдэгдлийн хяналтын олон улсын стандарт нэвтрүүлж хүнсний аюулгүй байдлыг сайжруулна).</p>	<p>Үлдэгдлийн үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө батлана. Суурь: 0 Зорилт: 1</p> <p>Малын өвчний (зооноз ба шүлхий) гаралт тархалтын эрсдлийг газарзүйн мэдээллийн систем ашиглан газрын зурагт хөрвүүлнэ. Суурь: 0 Зорилт: 2</p> <p>Мал сүрэгт нийтлэг гардаг өвчний гаралт тархалтын эрсдлийг ГМС ашиглан мэдээллийн санд оруулна. Суурь: 0 Зорилт: 1</p> <p>ГМС бүхий мэдээллийн санд нэвтрэдэг болох байгууллагын тоо (МЭҮГ, аймгийн МЭГ, сумын МЭҮТ) Суурь: 0 Зорилт: 22</p> <p>Малчдад малын өвчний гаралт тархалтын эрсдлийг мэдээлэх мэдээллийн сүлжээ Суурь: 0 Зорилт: 1</p>	<p>Батлагдсан хөтөлбөр төлөвлөгөө</p> <p>МЭҮГ-ын жил бүрийн тайлан</p> <p>МЭҮГ-ын жил бүрийн тайлан</p> <p>МЭҮГ-ын жил бүрийн тайлан</p> <p>МЭҮГ-ын жил бүрийн тайлан</p>	<p>Төрийн байгууллагуудын хүнд суртал</p> <p>Холбогдох мэдээлэл хангалтгүй байх</p> <p>Холбогдох мэдээлэл хангалтгүй байх</p> <p>Санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх</p> <p>Санхүүгийн эх үүсвэр, малчидад мэдээлэл түгээх араг хэрэгсэл хүрэлцэхгүй байх</p>
<p><b>Үр дүн 1.3.3</b> Хил дамжин халдварладаг малын халдварт өвчний хяналтын тогтолцоог бэхжүүлнэ.</p>	<p>Жил бүр вакцинажуулах малын тоо, '000 Суурь: 9,245.7 (2010) Зорилт: 10,632.56</p> <p>Сертификаттай лабораторийн тоо (хил дамжин халдварладаг өвчний хувьд УМЭАЦП-ийг лавлах лаборатори болгох) Суурь: 0 (2010) Зорилт: 1</p> <p>Жил бүр лабораторийн шинжилгээ, оношлогоонд хамруулагд малын тоо, '000 Суурь: 1,029 (2010) Зорилт: 2,000.0</p> <p>Орчин үеийн багаж төхөөрөмж (тарилга, угаалганд ашиглах зөөврийн хашаа, ванн), хөргүүртэй вакцины сав бүхий хувийн мал эмнэлгийн (805 ХМЭ) эзлэх хувь Суурь: 0 Зорилт: 40%</p>	<p>Монгол Улсын статистикийн эмхэтгэл, МЭҮГ-ын жил бүрийн тайлан</p> <p>Монгол Улсын статистикийн эмхэтгэл, МЭҮГ-ын жил бүрийн тайлан</p> <p>Монгол Улсын статистикийн эмхэтгэл, МЭҮГ-ын жил бүрийн тайлан</p> <p>МЭҮГ-ын жил бүрийн тайлан</p>	<p>Вакцины чанар хангалтгүй байх</p> <p>Мэдлэг, туршлага дутагдах</p> <p>Багаж тоног төхөөрөмж, туршлага дутагдах</p> <p>Санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх and production space</p>

**ХАХХ-ний тэргүүлэх чиглэл 2:** Байгаль орчинд ээлтэй технологи түүний дотор усалгаа, сэлгээний дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжиж бүтээмжийг нэмэгдүүлэн хүнсний шим тэжээллэг чанарыг сайжруулах.

ХАХХ-ний үр дүн	Шалгуур үзүүлэлт, суурь ба зорилтот түвшин	Баталгаажуулах эх үүсвэр	Эрсдэл
<p><b>Зорилт 2.1</b> Хөрсний үржил шимийг сайжруулах.</p>	<p>Хөрсний элэгдлийг зогсоох арга хэмжээнд хамрагдсан тариалангийн газар, '000 га Суурь: 98.9 (2011, ХХААХҮЯ-ны тайлан) Зорилт: 240.0</p> <p>Жил бүрийн үр тариа, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн хэмжээ, '000 тонн: а. Үр тариа: Суурь: 448.1 (2011) Зорилт: 566</p> <p>б. Төмс: Суурь: 199.2 (2011) Зорилт: 240</p> <p>в. Хүнсний ногоо: Суурь: 105.2 (2011) Зорилт: 200.0</p>	<p>Монгол Улсын статистикийн эмхэтгэл</p>	<p>Байгаль цаг уурын хүчин зүйлс</p>
<p><b>Үр дүн 2.1.1</b> Тариалангийн газрыг элэгдэл доройтлоос хамгаалах чадавхи сайжирч ойн зурвас байгуулах, дэвшилтэт технологи ашиглах, салхины хамгаалалт байгуулах зөвлөмж боловсруулна.</p>	<p>Доройтолд орсон тариалангийн талбайн эзлэх хувь Суурь: 56% (2010) Зорилт: 45%</p> <p>Тариалангийн газарт тарих суулгац бойжуулах газрын тоо Суурь: 3 Зорилт: 10</p> <p>Тариалангийн газарт ойн зурвас байгуулах талбайн хэмжээ, га Суурь: 1000 Зорилт: 10000</p>	<p>Үнэлгээний тайлан ҮХААЯ-ны жил бүрийн тайлан ҮХААЯ-ны жил бүрийн тайлан ҮХААЯ-ны жил бүрийн тайлан</p>	<p>Санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх Мэргэжлийн туршлага, чадвар дутагдах, байгалийн давагдашгүй хүчин зүйлс тохиолдох Мэргэжлийн туршлага, чадвар дутагдах, байгалийн давагдашгүй хүчин зүйлс тохиолдох</p>

## ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭ (ХАХХ) 2012-2016

<p>Үр дүн 2.1.2 Органик ба бусад төрлийн бордооны үйлдвэрлэл, зохистой хэрэглээг нэмэгдүүлэх зөвлөмж боловсруулна.</p>	<p>Жил бүрийн бактерийн ба органик бордооны үйлдвэрлэлийн хэмжээ, тонн          Суурь: 500          Зорилт: 2,000</p> <p>Органик ба бактерийн бордоо үйлдвэрлэдэг, борлуулдаг хэмжээ, тонн          Суурь: 1,000          Зорилт: 5,000</p> <p>Органик ба бактерийн бордоо ашиглаж га-аас авах төмс, хүнсний ногооны ургацын хэмжээ          Суурь: 13,3 тн/га          Зорилт: 15 тн/га</p>	<p>ҮХААЯ-ны жил бүрийн тайлан          ҮХААЯ-ны жил бүрийн тайлан          ҮХААЯ-ны жил бүрийн тайлан</p>	<p>Санхүүгийн эх үүсвэр, технологи хангалтгүй байх          Байхгүй          Байхгүй</p>
<p><b>Зорилт 2.2</b> Усалгаатай тариалан эрхлэх арга технологийг боловсронгуй болгох.</p>	<p>Усалгааны системийн тоо:          Суурь: 282          Зорилт: 500</p> <p>Усалгаатай талбайн хэмжээ, га:          Суурь: 45,400          Зорилт: 70,000</p> <p>Усалгаатай тариалангаас авах гол бүтээгдэхүүний хэмжээ, '000 тонн          а. Үр тариа:          Суурь: 19.8 (2011)          Зорилт: 36.8</p> <p>б. Төмс:          Суурь: 157.0 (2011)          Зорилт: 180.0</p> <p>в. Хүнсний ногоо:          Суурь: 106.1 (2011)          Зорилт: 172.5</p> <p>г. Жимс, жимсгэнэ:          Суурь: 0.7 (2010)          Зорилт: 35.0</p> <p>Усалгаатай тариалан эрхэлдэг аж аж ахуйн тоо          Суурь: 216          Зорилт: 350</p>	<p>ҮХААЯ-ны жил бүрийн тайлан          ҮХААЯ-ны жил бүрийн тайлан          ҮХААЯ-ны жил бүрийн тайлан          ҮХААЯ-ны жил бүрийн тайлан</p>	<p>Санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх          Санхүүгийн эх үүсвэр, технологи хангалтгүй байх          Санхүүгийн эх үүсвэр, технологи хангалтгүй байх          Санхүүгийн эх үүсвэр, технологи хангалтгүй байх</p>

<p>Үр дүн 2.2.1 Одоо ашиглагдаж байгаа усалгааны технологийг сайжруулах судалгаа хийж зөвлөмж боловсруулна.</p>	<p>Орхон, Сэлэнгэ, Хэрлэн голын хөндийд усалгааны систем байгуулах зөвлөмж боловсруулна. (61,156 га-д хийгдсэн судалгаанд үндэслэн) Суурь: 0 Зорилт: 3 (тус бүр дэлгэрэнгүй хайгуул, судалгаа, ажлын зураг)</p> <p>Орхон, Сэлэнгэ, Хэрлэн голын урсацыг зохицуулах далан барих техник, эдийн засгийн үндэслэл боловсруулна. Суурь: 0 Зорилт: 4</p> <p>3 голын хөндийд усалгааны систем баригдах талбай, га Суурь: 27,900 (131) Зорилт: 38,000 (190)</p>	<p>УХАААЯ-ны жил бүрийн тайлан УХАААЯ-ны жил бүрийн тайлан УХАААЯ-ны жил бүрийн тайлан</p>	<p>Санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх Санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх Барилгын компаниудын хүчин чадал, санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх</p>
<p>Үр дүн 2.2.2 Орхон, Сэлэнгэ, Хэрлэн голын хөндийд усалгааны систем, комплекс байгуулахад дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>Усалгааны технологийг сайжруулах зөвлөмж боловсруулна. Суурь: заавар, аргачлал хоцрогдсон Зорилт: шинэчилсэн заавар, аргачлал</p> <p>Усыг хэмнэлттэй ашигладаг усалгааны систем бүхий тариалангийн талбай, га Суурь: 30 (2011) Зорилт: 300 (дуслын ба гүний усалгаа)</p> <p>Усалгааны мэргэжилтэн, операторуудыг сургана. Суурь: 6 усалгааны инженер, 0 усалгааны ажилчин Зорилт: 30 усалгааны инженер, 100 усалгааны ажилчин</p>	<p>УХАААЯ-ны жил бүрийн тайлан УХАААЯ-ны жил бүрийн тайлан УХАААЯ-ны жил бүрийн тайлан</p>	<p>Байхгүй Тоног төхөөрөмж, эд ангийг зөв зохистой ашиглах ур чадвар дутагдах Сургалтын материаллаг бааз, сургагч багш дутагдах</p>
<p>Зорилт 2.3 Таримлын төрөл зүйлийг олшруулж газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.</p>	<p>Таримлын сэлгээг олшруулах үндэсний стратегийн баримт бичиг Суурь: 0 Зорилт: 1</p> <p>Сэлгээнд нэвтрүүлсэн хүнсний ногоо, жимс, тэжээлийн ба тосны ургамлын шинэ төрөл Суурь: 0 Зорилт: 3</p>	<p>УХАААЯ-ны жил бүрийн тайлан УХАААЯ-ны жил бүрийн тайлан</p>	<p>Дадлага, туршлага дугах Санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх, тариаланчдын туршлага, дадал дутагдах</p>

## ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭ (ХАХХ) 2012-2016

<p>Үр дүн 2.3.1 Улсын хэмжээнд тариалдаг үр тарианы төрлийг (хөх тариа, арвай, эрдэнэшиш г.м.) нэмэгдүүлэх чиглэлээр нотолгоонд суурилсан зөвлөмж, гарын авлага боловсруулна.</p>	<p>Хөх тариа, арвай, шар будааны жилийн үйлдвэрлэлийн хэмжээ, '000 тонн</p> <p>а. Хөх тариа: Суурь: 0.6 (2011) Зорилт: 2.4 (2016)</p> <p>б. Арвай: Суурь: 4.5 (2011) Зорилт: 18.0 (2016)</p> <p>в. Овьёс Суурь: 4.3 (2011) Зорилт: 17.2 (2016)</p> <p>г. Гурвалжин будаа: Суурь: 0.6 (2011) Зорилт: 3.4 (2016)</p> <p>д. Эрдэнэшиш: Суурь: 0.0 (2011) Зорилт: 5.0 (2016)</p> <p>Тариаланчдыг сургана. Суурь: 0 Зорилт: 60-70%</p>	<p>УХААЯ-ны жил бүрийн тайлан, Монгол Улсын статистикийн эмхэтгэл</p>	<p>Машин, тоног төхөөрөмж, нөү-хау, санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх, байгалийн давагдашгүй хүчин зүйлс тохиолдох</p>
<p>Үр дүн 2.3.2 Хүнсний ногоо, жимс жимсгэнэ (чацаргана) үйлдвэрлэх, боловсруулах талаар нотолгоонд суурилсан зөвлөмж бэлтгэнэ.</p>	<p>Жимс, жимсгэнийн талбайн хэмжээ, '000 га: Суурь: 3.9 (Чацаргана үйлдвэрлэгчдийн холбооны мэдээ) Зорилт: 20.0</p> <p>Жимс, жимсгэнийн жилийн ургацын хэмжээ, '000 тонн: Суурь: 0.9 Зорилт: 35.0</p> <p>Жимс, жимсгэнэ боловсруулах ТХХТ-ийн тоо Суурь: 2 Зорилт: 5</p>	<p>Монгол Улсын статистикийн эмхэтгэл, УХААЯ-ны жил бүрийн тайлан, "Чацаргана" үндэсний хөтөлбөрийн тайлан</p> <p>Монгол Улсын статистикийн эмхэтгэл, УХААЯ-ны жил бүрийн тайлан, "Чацаргана" үндэсний хөтөлбөрийн тайлан</p> <p>УХААЯ-ны жил бүрийн тайлан, "Чацаргана" үндэсний хөтөлбөрийн тайлан</p>	<p>Санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх, байгалийн давагдашгүй хүчин зүйлс тохиолдох</p> <p>Санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх, байгалийн давагдашгүй хүчин зүйлс тохиолдох</p> <p>Байхгүй</p>

<p><b>Үр дүн 2.3.3</b> Чихрийн манжин, тосны ургамал зэрэг техникийн таримал тариалах тухай нотолгоонд суурилсан зөвлөмж боловсруулна.</p>	<p>Чихрийн манжин, тосны ургамлын жилийн ургацын хэмжээ, ᠐00 тонн          а. Чихрийн манжин:          Суурь: 0.0 (2011)          Зорилт: 0.5 (2016)           б. Тосны ургамал:          Суурь: 4.5 (2011)          Зорилт: 20.0 (2016)           Сэлгээнд чихрийн манжин, тосны ургамал тариалах зөвлөмж боловсруулна.          Суурь: 0          Зорилт: 2           Чихрийн манжингийн аж ахуйн тоо          Суурь: 0          Зорилт: 1</p>	<p>УХАААЯ-ны жил бүрийн тайлан, <a href="http://www.pmis.gov.mn">http://www.pmis.gov.mn</a>          Монгол Улсын статистикийн эмхэтгэл           УХАААЯ-ны жил бүрийн тайлан           УХАААЯ-ны жил бүрийн тайлан</p>	<p>Машин, тоног төхөөрөмж, нөү-хау, санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх, байгалийн давагдашгүй хүчин зүйлс тохиолдох           Туршлага дутагдах           Машин, тоног төхөөрөмж, нөү-хау, санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх, байгалийн давагдашгүй хүчин зүйлс тохиолдох</p>
<p><b>Зорилт 2.4</b> Газар тариалангийн үйлдвэрлэл, бүтээмжийг нэмэгдүүлэхэд дэвшилтэт арга технологийг ашиглах.</p>	<p>Төмс, хүнсний ногооны тариалангийн механикжуулалтыг сайжруулна.          Суурь: 20% (2011)          Зорилт: 40%           Үр тарианы үрийн шинэчлэл (шинэ сорт нэвтрүүлэх) хийнэ.          Суурь: 50% (2011)          Зорилт: 60%           Хүйтэнд тэсвэртэй богино болцтой үр тарианы сортыг сорьж, шинээр нэвтрүүлнэ.          Суурь: 1          Зорилт: 5           Ган, өвчинд тэсвэртэй үр тарианы сорт сорьж нэвтрүүлнэ.          Суурь: 3          Зорилт: 5</p>	<p>УХАААЯ-ны жил бүрийн тайлан           УХАААЯ-ны жил бүрийн тайлан</p>	<p>Санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх           Санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх, байгалийн хүчин зүйлс нөлөөлөх</p>
<p><b>Үр дүн 2.4.1</b> Бодлогын ба үйлдвэрлэлийн түвшинд төрийн байгууллага, фермерүүдийн үр үржүүлэх, үйлдвэрлэх чадавхийг сайжруулна.</p>	<p>Өвлийн хүлэмжийн аж ахуйн тоо          Суурь: 12          Зорилт: 50           Төмс, хүнсний ногоо тариалагчдад машин техникээр үйлчлэх дундын үйлчилгээний төвийн тоо          Суурь: 30          Зорилт: 90</p>	<p>УХАААЯ-ны жил бүрийн тайлан           УХАААЯ-ны жил бүрийн тайлан</p>	<p>Лабораторийн тоног төхөөрөмж, санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх           Лабораторийн тоног төхөөрөмж, санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх           Санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх, өвлийн улиралд газар тариалан эрхлэх дадал, туршлага дутагдах           Санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх</p>
<p><b>Үр дүн 2.4.2</b> Жижиг аж ахуйд тохиромжтой механикжуулалтын төсөл хэрэгжүүлнэ.</p>	<p>Төмс, хүнсний ногоо тариалагчдад машин техникээр үйлчлэх дундын үйлчилгээний төвийн тоо          Суурь: 30          Зорилт: 90</p>	<p>УХАААЯ-ны жил бүрийн тайлан           УХАААЯ-ны жил бүрийн тайлан</p>	<p>Лабораторийн тоног төхөөрөмж, санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх           Санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх, өвлийн улиралд газар тариалан эрхлэх дадал, туршлага дутагдах           Санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх</p>

## ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭ (ХАХХ) 2012-2016

ХАХХ-ний тэргүүлэх чиглэл 3: Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд дасан зохицож даван туулах, удирдах зорилгоор байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хөгжүүлэх.

ХАХХ-ний үр дүн	Шалгуур үзүүлэлт, суурь ба зорилтот түвшин	Баталгаажуулах эх үүсвэр	Эрсдэл
<b>Зорилт 3.1</b> Гамшгийн эрсдлийг бууруулах, эрт мэдээлэх замаар хүн амын хүнс, тэжээлийн баталгаат байдлыг (ХТББ) хангах.	Үндэсний стратеги, бодлогын баримт бичиг батлагдана. Суурь: 0 Зорилт: 1	ҮХААЯ-ны жил бүрийн тайлан	Менежмент дутагдах
<b>Үр дүн 3.1.1</b> Хүнс, тэжээлийн баталгаат байдлыг хангах зорилгоор гамшгийн эрсдлийг бууруулах бодлого, зохицуулалтын хүрээ бий болгоно.	Бодлого, зохицуулалтын хүрээ бий болно. Суурь: 0 Зорилт: 1	ҮХААЯ-ны жил бүрийн тайлан	Хамтын ажиллагааны удирдлага, зохион байгуулалт дутагдах
<b>Үр дүн 3.1.2</b> Нэгдсэн мэдээллийн сүлжээ, эрт мэдээлэх тогтолцоо бий болгоно.	Эрт мэдээлэх тогтолцоо ба мэдээллийн сан байгуулагдана. Суурь: 0 Зорилт: 1	ҮХААЯ-ны жил бүрийн тайлан	Санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй бай, шинэ бодлого хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт дутагдах
<b>Зорилт 3.2</b> Хамтын оролцоотой ойн менежментийг хөгжүүлэх.	Хамтын оролцоотой байгалийн нөөцийн менежмент, ан амьтан хамгаалах, ойн нөөцийг зохистой ашиглах бодлогын зохицуулалт  Суурь: "Ойг гэрээгээр ашиглуулах журам" - аар зөвхөн ойн асуудлыг шийдвэрлэдэг Зорилт: Байгалийн нөөцийн менежмент, ан амьтан хамгаалах, ойн нөөцийг зохистой ашиглахад хамтын оролцоог нэмэгдүүлэх үндэсний зохицуулалт сайжрах  Хамтын оролцоотой менежментэнд хамрагдсан ойн талбайн хэмжээ Суурь: Ойн нөхөрлөлд 4 сая га ойг эзэмшиж байна (Ойн газрын жилийн тайлан, 2011) Зорилт: Ойн нөхөрлөлд 8 сая га ойг эзэмшүүлнэ	Хууль зүйн мэдээллийн сан <a href="http://www.legalinfo.mn">http://www.legalinfo.mn</a>  Ойн газрын жил бүрийн тайлан, БОНХЯ-ны хоёр жил тутмын Байгаль орчны тайлан	Санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх  Шинэ бодлого хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт дутагдах



<p><b>Үр дүн 3.2.1</b> БОНХЯ, Ойн газар, аймгуудын ойн ангийн хамтын оролцоотой ой, загас, ан амьтдын менежментийн чадавхийг сайжруулна.</p>	<p>Хамтын оролцоотой ой, загас, ан амьтдын менежментэнд ажилтнуудыг сургана. Суурь: 3,000 ажилтнаас 0 (2012) Зорилт: 100 сургагч багш</p>	<p>Ойн газрын жил бүрийн тайлан, БОНХЯ-ны хоёр жил тутмын Байгаль орчны тайлан</p>	<p>Санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх</p>
